

ГЭР БҮЛИЙН  
ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ  
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН  
ДАВХАРДАЛ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



“САИН ТУРШЛАГА”  
ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛЛАГА

## ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ДАВХАРДАЛ

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар

2022

ННА 67.408  
ДАА 345  
Б-337



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ



“САЙН ТУРШЛАГА”  
ТӨРИЙН БУС  
БАЙГУУЛЛАГА

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ УЙЛДЭХ  
ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ДАВХАРДАЛ  
БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**СУДАЛГААНЫ БАГ:**

Багийн ахлагч: Ж.Эрдэнэбулган, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал,  
доктор (Ph.D)

Судлаачид: Ж.Батмөнх, Өмгөөллийн “Кэй И Партнерс” ХХН-ийн хуульч,  
өмгөөлөгч

Э.Цэлмэг, Өмгөөллийн “Легал Линк Си Би Эй” ХХН-ийн хуульч

“САЙН ТУРШЛАГА” төрийн бус байгууллага нь 2014 онд эрх зүйн салбарт  
судалгаа эрхлэх, сургалт зохион байгуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ  
төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх зорилгоор үүсэн байгуулагдсан. Энэхүү  
судалгааг ННФ-ын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэв.

© Нээлттэй Нийгэм Форум, 2022

Хаяг: Жамъян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар 14240  
Утас: 976-73113207  
Веб: <http://www.forum.mn>  
И-мэйл: osf@forum.mn

“Би Си Ай” ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

ISBN 978-9919-9840-4-5

## **АГУУЛГА**

ТОВЧИЛСОН УГИЙН ЖАГСААЛТ .....	5
УДИРТГАЛ.....	6
Судлагдсан байдал.....	9
Судалгааны зорилго .....	10
Судалгааны зорилт.....	10
Судалгааны ач холбогдол .....	10
Судалгааны арга зүй.....	11
 НЭГ. ГЭР БУЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ, ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ЗӨРЧЛИЙН ЯЛГАА .....	13
1.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх тухай ойлголт, онцлог .....	13
1.2. Гэмт хэрэг болон зөрчлийн ялгаатай байдал.....	16
 ХОЁР. ГЭР БУЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ПРАКТИК АСУУДАЛ .....	28
2.1. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн талаарх эрх зүйн зохицуулалт .....	28
2.2. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн практик асуудал.....	35
 ГУРАВ. ГЭР БУЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ БУСАД УЛС ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ .....	76
 ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ.....	105
 ХАВСРАЛТ.....	111

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улс 2016 онд анх удаа “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг гэж Эрүүгийн хуульдаа тусгасаны дээр зарим төрлийн гэмт хэргийн хүндруүлэх бүрэлдэхүүнд оруулсан болно. Үүний зэрэгцээ Зөрчлийн тухай хуульд “гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” хэмээх зөрчлийг тусгаж, хүлээлгэх хариуцлагыг тогтоосон билээ. Эдгээр хууль хэрэгжээд багагүй хугацаа өнгөрч байгаа тул гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд гарч буй ахиц дэвшил, тулгамдаж буй асуудлыг тодруулах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Нээлттэй Нийгэм Форумаас эрхлэн энэ асуудлаар зарим судалгаа хийсэн бөгөөд энэ удаагийн судалгаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг болон зөрчлийн ялгаа, зааг, давхардал, хийдлийг судалснаараа онцлогтой. Сайн туршлага ТББ хийж гүйцэтгэсэн “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн давхардал” сэдэвт энэхүү судалгааны дүнг Танд хүргэж байгаадаа баяртай байна. Тус судалгаагаар Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль хэрэглээний явцад тулгамдаж буй асуудлыг шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, мэргэжилтнүүдийн санал бодол, хууль тогтоомжийн шинжилгээнд тулгуурлан тодорхойлохын зэрэгцээ энэ асуудлаарх олон улсын хэм хэмжээ, зарим гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан шинжлэн дүгнэжээ.

Бид манай улсад өrnөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, хэрэгжилтийн мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд энэ хүрээнд 30 орчим судалгаа олны хүртээл болсныг энэ ташрамд дурдахад таатай байна. Мөн дээрх судалгааны үр дүнг олон нийтэд танилцуулах, бодлого, шийдвэрт тусгзуулах зорилгоор цуврал хэлэлцүүлэг өrnүүлж, хэлэлцүүлгийн видео бичлэгийг олон нийтэд түгээдэг юм. Та бүхэн манай цахим хуудас, нийгмийн сүлжээнээс эдгээр хэлэлцүүлгийн видеог үзэх боломжтойг энэ ташрамд дуулгахад таатай байна. Бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

*ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал*

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГБХТтХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ГБХХЭГХТХ	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс
ГХУСАЗЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
ЗтХ	Зөрчлийн тухай хууль
НУБХАС	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан
ОХУ	Оросын Холбооны Улс
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШХУ	Швейцарын Холбооны Улс
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХЕА	Эрүүгийн хуулийн ерөнхий анги
ЭХТА	Эрүүгийн хуулийн тусгай анги
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

## УДИРТГАЛ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэсний дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдэлнэ”, 3 дахь хэсэгт “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй”, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “...гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. ...Гэр бүл, эх наялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...эрхтэй” гэж тус тус заасан. Энэхүү үндсэн эрхийг баталгаажуулж 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль баталсан бөгөөд тус хуулийт 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдөр шинэчлэн найруулж баталсан. Мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 120<sup>1</sup> дугаар зүйл болон Захиргааны хариуцлагын тухай хуулийн 221 дүгээр зүйлд гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг, зөрчил хэмээн үзэж нэмэлт оруулсан. Үүний дараа 2015 оны шинэ Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг, зөрчил хэмээн тодорхойлж, зарим гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон оруулсан.

Гэр бүл гэж гэрлэлтийн үр дүнд буй болсон, эд хөрөнгийн бус амины болон эд хөрөнгийн эрх, үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий гэр бүлийн гишүүдийг ойлгодог. Гэр бүлийн гишүүн гэдэгт эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа төрсөн, дагавар, үрчлэн авсан хүүхэд болон төрөл, садны хүнийг хамааруулдаг.<sup>1</sup> Гэр бүлийн гишүүд нь тэгш эрх эдлэхээс гадна бие биедээ үнэнч байх, халамжлах, хүндэтгэх зэрэг ёс суртахууны үүрэг хүлээхийн

<sup>1</sup> Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйл. [www.legalinfo.mn/law/details/226?law-id=226](http://www.legalinfo.mn/law/details/226?law-id=226)

дээр тэжээн тэтгэх, бие биеэ аливаа хэлбэрээр хүчирхийлэхгүй байх зэрэг хуульд заасан үүрэг хүлээх бөгөөд<sup>2</sup> хэрэв ямар нэгэн хүчирхийлэл үйлдвэл Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ. Энэ нь төр иргэнийхээ үндсэн эрх, гэр бүлийн ашиг сонирхлыг хамгаалах үүргээ биелүүлж буй хэрэг юм.

2018 оны 6 дугаар сарын 18-ны өдөр НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо хамтран жендерт суурилсан хүчирхийллийн тархалт, шалтгаан, үр дагаврын талаар Монгол Улсад анх удаа явуулсан судалгааны тайланг танилцуулсан. Энэхүү тайлангаар сүүлийн 12 сарын хугацаанд ойр дотнын хамтрагч болон бусад этгээдийн үйлдсэн хүчирхийлэлд өртсөн байдал болон амьдралдаа хүчирхийлэлд өртсөн байдлыг тодруулахаар 7,300 гаруй эмэгтэйтэй ярилцлага хийхэд дараах үр дүн гарсан байна. Үүнд:

- Хамтрагчтай байсан болон одоо хамтрагчтай байгаа эмэгтэйчүүдийн 57.9 хувь нь бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны болон эдийн засгийн хүчирхийллийн хэлбэрүүдээс аль нэгд нь юм уу эсвэл хэд хэдэн хэлбэрийн хүчирхийлэлд амьдралдаа өртсөн байв. Мөн тэдний 31.2 хувь нь бие махбодын болон бэлгийн хүчирхийлэлд өртжээ.
- Хамтрагчийн үйлдсэн аливаа хэлбэрийн хүчирхийлэл Хэнтий, Дархан-Уул, Өмнөговь, Улаанбаатар, Говьсүмбэр аймагт хамгийн өндөр байсан бол үүнээс бие махбодын болон бэлгийн хүчирхийлэл Дархан-Уул, Өмнөговь, Говьсүмбэр, Булган, Ховд аймагт хамгийн их байна.
- Хүчирхийллийн тархалтын түвшнээр авч үзвэл Улаанбаатар хот хамгийн их хүн амтай учраас хүчирхийлэлд өртөгсдийн тоо нь бусад бүсийнхээс их ч хамгийн өндөр үзүүлэлттэй байгаагүй.

<sup>2</sup> Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйл. [www.legalinfo.mn/law/details/226?law-id=226](http://www.legalinfo.mn/law/details/226?law-id=226)

- Хамтрагч бус этгээдийн хүчирхийлэл залуучуудын дунд түгээмэл байна. 15-аас дээш насны эмэгтэйчүүдийн 17.3 хувь нь бие махбодын хүчирхийлэлд амьдралдаа өртсөн бол 4.5 хувь нь сүүлийн 12 сард уг хүчирхийлэлд өртжээ.
- 10 эмэгтэй тутмын нэг нь бусдын үйлдсэн бэлгийн хүчирхийлэлд 15 нас хүрэхээсээ өмнө өртсөн байна.
- Нийгэм, эдийн засгийн статусаас үл хамааран дөрвөн эмэгтэй тутмын нэг нь “хэрэв эхнэр нь үнэнч бус байвал нөхөр нь цохиж, зодож болно” гэдэгтэй санал нийлжээ.<sup>3</sup>

Дээрх байдлаас үзэхэд Монгол Улсад эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийн түвшин өндөр байх бөгөөд аливаа хэлбэрийн хүчирхийлэл, ялангуяа бие махбодын болон бэлгийн хүчирхийллийн эсрэг урьдчилсан арга хэмжээ авах, хүчирхийлэл үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх шаардлагатай байгааг харуулж байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Э.Баяrbаясгалантай хийсэн ярилцлагад “Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2021 оны эхний гурван сарын байдлаар 388 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 39 хувиар өсжээ. Харин дуудлага, мэдээллийг авч үзэхэд 11,300 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхтэй адил байна”, Нийслэлийн Цагдаагийн газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Б.Батзоригтой хийсэн ярилцлагад “Өнөөдрийн байдлаар нийслэлийн хэмжээнд удаа дараа гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг 2,000 гаруй иргэн байна. Үүнээс аюулын зэрэг өндөртэй 200 гаруй өрх байна” гэж тус тус дурдажээ.<sup>4</sup>

Эндээс харахад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг буурахгүйгээр үл барам аюулын зэрэг өндөртэй цөөнгүй өрх байгаа нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн

<sup>3</sup> Хүчирхийллийн нүүцгэн үнэн: Жендерт сууринласан хүчирхийллийн судалгааны тайлан-2017, НҮБ-ын Хүн амын сан, <https://mongolia.unfpa.org/mn>

<sup>4</sup> <https://police.gov.mn/a/5506>

асуудалд анхаарал хандуулах шаардлагатай болохыг тод харуулж байна. Гэтэл 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх асуудлыг ялган зааглаж, зөв томьёолж чадаагүй нь мөрдөгч, прокурор, шүүхээс хуулийн агуулгыг янз бүрээр тайлбарлан, ялгамжтай шийдвэр гаргах нөхцөл болжээ. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн зэрэг ойлголтыг холбогдох хуулиудад өөр өөрөөр тодорхойлж, гэмт хэрэг, зөрчлийн бүрэлдэхүүний объектив шинжийг оновчтой зохицуулж чадаагүйгээс хэргийн зүйлчлэлд хуулийн хийдэл үүсжээ. Өөрөөр хэлбэл, тасралтгүй гарч буй гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчилд давхардал үүссэнээр нэг талаас хүчирхийлэлд өртөгсөд хохирох, нөгөө талаас хүчирхийлэл үйлдсэн этгээд ял завших боломж бүрджээ.

Иймд хөндлөнгийн судлаачдын байр сууриас гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх тухай ойлголт, онцлог, холбогдох хуулиудын зохицуулалтын эерэг болон сөрөг үр дагавар, шалтгаан зэргийг тодорхойлж, бусад улсын эрх зүйн зохицуулалтын онцлог, оновчтой зохицуулалтыг харьцуулан судалж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Эрүүгийн хуульд хэрхэн зөв томьёолох талаар санал, дүгнэлт гаргах зорилго бүхий суурь судалгаа хийх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

### **Судлагдсан байдал**

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаар Ханс Зайделийн сангаас гаргасан видео хичээл<sup>5</sup>, Монголын криминологичдын холбооноос бэлтгэсэн “Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь” сэдэвт судалгааны тайлан<sup>6</sup> болон Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газраас хамтран гаргасан “Гэр бүлийн хүчирхийлэл

<sup>5</sup> <https://mongolia.hss.de/mn/mehdeheh-mehdehehlehl/detail/translate-to-mongolian-schafft-haeusliche-gewalt-news4469/>

<sup>6</sup> INL Criminology report\_Mon.pdf

үйлдэх гэмт хэргийн криминологи судалгааны тайлан” зэрэгт ерөнхий байдлаар тусгагдсанаас өөр энэ чиглэлээр дагнан судалсан бүтээл байхгүй байна.

### **Судалгааны зорилго**

Энэхүү судалгааны зорилго нь гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хууль тогтоомжийн харилцан уялдааг судлах, гэмт хэрэг болон зөрчил хоорондын давхардлыг зааглах талаар бусад улс орны туршлагыг судлах, цаашид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Эрүүгийн хуульд оновчтой тодорхойлох талаар санал, зөвлөмж боловсруулахад оршино.

### **Судалгааны зорилт**

Судалгааны багийн хувьд дээрх судалгааны ажлын үндсэн зорилгод хүрэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллалаа. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх ойлголт, онцлогийг тодорхойлох;
- Гэмт хэрэг, зөрчлийн ялгаа, заагийг судлах;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн давхардлыг олж тогтоох;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хийдлийг тодруулах;
- Энэ талаар бусад улс орны эрх зүйн зохицуулалт, чиг хандлага, туршлагыг судлах;
- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг оновчтой тодорхойлох талаар санал, зөвлөмж гаргах зэрэг болно.

### **Судалгааны ач холбогдол**

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь ихэвчлэн гэр бүлийн хүрээнд үйлдэгддэг тул хохирогч гомдол, мэдээлэл гаргах нь түгээмэл биш. Гомдол, мэдээллийн дагуу цагдаагийн

байгууллага мөрдөн шалгах ажиллагаа явуулах үеэр хохирогч дарамтад орсноос айж эмээх, гомдол, мэдээллээсээ татгалзах эсхүл гэмт хэргийн шинжтэй үйлдэл нь бүрэн нотлогддоггүй зэрэг хүндрэл тулгардаг. Мөн холбогдох хуулийн зохицуулалт тодорхой бус байгаа нь олон нийт, хуульч, судлаачдын анхаарлыг татах байна. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт дүн шинжилгээ хийж, санал, зөвлөмж боловсруулах нь хууль тогтоогч, иргэний нийгмийн байгууллага, хууль хэрэгжүүлэгч байгууллага, иргэдэд чухал ач холбогдолтой юм.

### **Судалгааны арга зүй**

Судалгааны багийн зүгээс тавьсан үндсэн зорилго, зорилтдоо хүрэхийн тулд энэхүү судалгаанд дараах судалгааны аргуудыг ашиглалаа. Үүнд:

- *Кейс судлалын арга*

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, ялангуяа Улсын Дээд шүүхийн тогтоолуудыг сонгон авч дүн шинжилгээ хийв. Ингэснээр шүүх гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн зүйлчлэлийг хэрхэн тайлбарлан, дүгнэж байгааг тодруулахыг зорилоо.

- *Баримт бичигт дүн шинжилгээ хийх арга*

Энэхүү судалгаанд холбогдох баримт бичгүүдийг дараах ангилалд оруулан дүн шинжилгээ хийв. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаар судалгаа, шинжилгээ хийсэн дотоодын болон гадаадын эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлал, байр суурь, судалгааны бүтээл;
- Эрх зүйн орчны хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн зохицуулалтын онцлог, туршлага;

- Статистик мэдээлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээллийг нарийвчлан авч үзэв.
- *Харьцуулалтын арга*

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой бусад улс орны туршлага, эрх зүйн орчныг харьцуулан эрх зүйн хүрээнд үндэслэн судлав. Харьцуулан судлах хүрээнд Монгол Улстай эрх зүйн тогтолцооны хувьд ойролцоо болон сайн туршлагатай улс орнуудын эрүүгийн хууль тогтоомжийн зохицуулалт, онцлогийг тодорхойллоо. Ингэхдээ макро болон микро харьцуулалтыг тогтолцоо, үр нөлөөний хувьд авч үзэв.

- *Ярилцлагын арга*

Төрийн болон төрийн бус холбогдох байгууллагуудын судалгаа, мэдээллийн ажилтан, судлаач, эрдэмтэн, багш, өмгөөлөгч, прокурор, шүүгч нартай судалгааны мэдээлэл цуглуулах, судалгааны хүлээн зөвшөөрөгдөх үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор ганцаарчилсан уулзалтууд хийллээ. Түүнчлэн бодлого боловсруулагчдын үзэл, хандлагыг танин мэдэхэд уг судалгааны аргыг ашиглав.

# **НЭГ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ, ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ЗӨРЧЛИЙН ЯЛГАА**

## **1.1. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНЦЛОГ**

Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэхтэй холбоотой харилцааг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар зохицуулсан байдаг. Тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүйг гэр бүлийн хүчирхийлэл гэнэ” хэмээн тодорхойлсон. Тус тодорхойлолтоос үзвэл гэр бүлийн хүчирхийлэл нь дараах шинжүүдийг агуулахаар байна.

1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд: Эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд, тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү, гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээдүүдийг ойлгохоор байна.
2. Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүн: Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээдийг ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан хүмүүсийн хоорондын харилцааг хэлнэ.
3. Хүчирхийллийн хэлбэр: Хүчирхийлэл нь бие махбодын, сэтгэл санааны, эдийн засгийн, бэлгийн гэсэн дөрвөн хэлбэрээр илрэн гардаг.<sup>7</sup>

<sup>7</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйл. [www.legalinfo.mn/law/details/12393?lawid=12393](http://www.legalinfo.mn/law/details/12393?lawid=12393)

- A. Бие махбодын хүчирхийлэл:** Хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулсан эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Тухайлбал алгадах, өшиглөх, цохих, зодох, үсдэх гэх мэтээр биед гэмтэл учруулах, түлэх, шарх, сорви үүсгэх, хутга, мэс, зэвсгийн чанартай зүйл хэрэглэн сүрдүүлэх, гэмтээх, бэرتээх, амь насыг хохироох гэх мэт.
- Б. Сэтгэл санааны хүчирхийлэл:** Хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг албадах, үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэсэн үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Тухайлбал, бусдын дэргэд үг хэлээр доромжлох, байнга хараалын үг хэллэг хэрэглэх, бүдүүлэг байдлаар харилцах, бусадтай сул талаар нь харьцуулах, хийж буй зүйлийг нь байнга хянах, хардах, алхам бүрийг нь мөрдөн мөшгөх, түүнтэй холбоотой хэн нэгнийг болон зарим зүйлийг хохирооно, сүйтгэнэ гэж айлгах, өөрийгөө ална гэж сүрдүүлэх, найз нөхөд болон сонирхдог зүйлгүй болгох, хувийн захидал задлах, утсаар ярих тоо, хугацааг хязгаарлах, өөрийн гэр бүлээс гадуур амрагийн явдлаа ярих, найз нөхөд, ах дүүсийнхээ хажууд дорд үзэх, худал ярих, худалч, хулгайч, сэтгээцийн өвчтэй, хамгийн муу хүн гэдэгт итгүүлэх, хүсэл мөрөөдөл, үзэл бодлыг нь үл ойшоох, гутаах, доромжлох, хараах, загнах, буруутгах, нэр хоч өгөх, гоочлох, тавлах, айлган сүрдүүлэх, зандрах, өөртөө болон амьдралд итгэх итгэлгүй болгох, улмаар амиа хорлоход хүргэх гэх мэт.
- В. Эдийн засгийн хүчирхийлэл:** Цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах орлого, хуваарь болон дундын эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах, орлого олох боломжийг нь хязгаарлах, шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан эсхүл эд хөрөнгийн хохирол учруулсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Тухайлбал, мөнгөн орлогод нь хяналт тавих, орлогын эх

Үүсвэргүй болгох, эх үүсвэрээс нь салгах, эдийн засгийн эрх мэдэлгүй болгох, гэрийн бүх мөнгийг хянаж, цагдах, өөрийн гэсэн мөнгөтэй байхыг үл зөвшөөрөх, ажил хийх болон боловсрол олоход нь саад хийх, зарцуулсан мөнгийг нь нэг бүрчлэн тооцох, мөнгөөр байнга гачигдуулах, мөнгө үрж, хэрэггүй зүйлд зарлаа гэж буруушаах, хувцас, ахуйн хэрэглээний зардлаар гачигдуулах гэх мэт.

- Г. *Бэлгийн хүчирхийлэл:* Эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ. Тухайлбал, хүслийг үл харгалзан хүч хэрэглэн хурьцал үйлдэх, хүчиндэх, хууран мэхлэх, айлгах, сүрдүүлэх замаар бэлгийн дур хүслээ хангах, бэлэг эрхтнийг нь гэмтээх, элдэв аргаар тарчлаах, бэлгийн харилцаанд ёс бусаар орох, орохыг шаардах, оруулах гэх мэт.
4. *Үйлдэл, эс үйлдэхүй:* Үйлдэл гэдэг нь хүний идэвхтэй байдал, үйл хөдлөлөөр илэрхийлэгдэнэ. Эс үйлдэхүй нь тухайн хүн тодорхой нөхцөлд өөрийн хийх ёстой байсан буюу гүйцэтгэх ёстой байсан үйлдлийг хийгээгүйгээс нийгэмд аюултай хор уршиг бий болгохыг хэлнэ.<sup>8</sup>

Гэр бүлийн хүчирхийлэл нь ихэвчлэн эдийн засаг, эрх мэдлийн тэгш бус харилцаатай гэр бүлийн гишүүдийн дунд үйлдэгддэг. Энэ нь хэн нэг хүний ганц удаагийн санамсаргүй үйлдэл бус харин тодорхой зорилготой, урьдаас төлөвлөн ахин дахин давтан үйлдэж даамжирдгаараа онцлогтой. Мөн гэр бүлийн хүчирхийлэл нь эргэх холбоо бүхий дараах дөрвөн үе шаттай байдаг байна.<sup>9</sup> Үүнд:

<sup>8</sup> НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлаг, Хүйсийн тэгш эрхийн төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ., 2018, 12-14 дэх тал.

<sup>9</sup> Мөн тэнд. Дэлгэрэнгүйг 14-15 дахь талаас үзэх.



## 1.2. ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ЗӨРЧЛИЙН ЯЛГААТАЙ БАЙДАЛ

### 1.2.1. Гэмт хэргийн тухай ойлголт

Эрүүгийн эрх зүйн ерөнхий ангийн гол судлагдахуун бол гэмт хэрэг юм. Гэмт хэргийг гадаад, дотоодын эрдэмтэд янз бүрээр тодорхойлсоор байгаа бөгөөд өнөөг хүртэл нэгдсэн нэг тодорхойлолтод хүрээгүй байна. Учир нь гэмт хэрэг гэх ухагдахуун нь улс үндэстний эрүүгийн эрх зүйн үзэл баримтлал, нийгэм, түүх, эрх зүйн тогтолцооны онцлогтой салшгүй хамааралтай.<sup>10</sup>

Орчин үед эрүүгийн хуульдаа “гэмт хэрэг” гэх ойлголтыг хуульчлан томьёолсон байдлыг мөн чанар, шалгуур, агуулгаар нь формаль болон материалист гэсэн хоёр ангилалд авч үздэг. Формаль хандлагаар гэмт хэрэг нь нийгмийн мөн чанарын илэрхийлэл биш, нийгэмд аюултай үйлдэл ч биш, харин ялын үр дагаврын хамааралт байдлаар эрүүгийн эрх зүйн журам, хэм хэмжээнүүдээр хориглосон, хууль зөрчсөн эрх зүйн бус үйлдэл, үйл явдлууд юм. Тухайлбал, Германы эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн 1-д “Гэмт хэрэг гэдэг нь нэгээс доошгүй жил хорих ял оногдуулахаар заасан хууль бус үйлдэл” гэж заасан. Харин материалист хандлагаар нэг талаас эрүүгийн хуулиар хориглосон хэм хэмжээний шинжийг, нөгөө талаас нийгэмд аюултай байх шинжийг агуулна. Гэмт хэргийн шинжүүд нь гэмт хэрэг гэх ойлголтыг тодорхойлоход ач холбогдол

<sup>10</sup> Т.Золбоо, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Гэмт хэргийн бүтээц, УБ., 2018, 36 дахь тал.

бүхий шалгуур нөхцөл, онцлог байдлыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийг категоричлон гадаад, дотоод шинжээр нь ялган авч үзэх нь уг ойлголтыг түгээмэл болгон тодорхойлох явдлыг ихээхэн хязгаарлахад хүргэдэг.<sup>11</sup>

Монгол Улсын Эрүүгийн хуульд чухам юуг гэмт хэрэг гэж үзэх тухай тодорхойлолтыг хуульчилсан нь орчин үед эрх зүйт төрийг бүрдүүлэн төлөвшүүлэхэд онол, практикийн ач холбогдолтой.<sup>12</sup> Гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, эв нэгдэл, хил хязгаарын халдашгүй байдал, батлан хамгаалах хүчин чадал, хүний аюулгүй байдал, эрх, эрх чөлөө, үндэсний баялаг, байгаль орчин, төр, захиргааны байгууллагын хэвийн үйл ажиллагаа, төрийн албан хаагчдын хуульд нийцсэн зөв үйл ажиллагаа, халдашгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, мэдээлэл, технологийн аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, цэргийн эрх зүйн журам, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайван зэрэг нийгмийн амин чухал эрх ашигт халдаж хохирол учруулсан, нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй юм.<sup>13</sup>

Тиймээс Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “энэ хуулийн тусгай анgid заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно”, 2 дахь хэсэгт “энэ хуулийн тусгай анgid заасан тохиолдолд гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хохирол, хор уршиг учирсныг гэмт хэрэгт тооцно” гэж тус тус заасан. Гэмт хэрэг нь эрх зүйн бусад зөрчлөөс дараах шинжээр ялгагдана.<sup>14</sup>

- Эрүүгийн хуулийн тусгай анgid заасан байх: Эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэрэгт тооцогдоно. Энэ шинж нь эрүүгийн эрх зүйн чухал зарчим болох “nul-

<sup>11</sup> Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2017, 90 дэх тал.

<sup>12</sup> Г.Совд, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2002, 23 дахь тал.

<sup>13</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 69 дэх тал.

<sup>14</sup> Г.Эрдэнэбат, Ж.Эрдэнэбулган, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн удиртгал, УБ., 2004, 83 дахь тал.

lum crimen sine lege” буюу эрүүгийн хуульд заагаагүй бол гэмт хэрэг биш гэсэн зарчимд үндэслэнэ. Тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэж үзэх, тэдгээрт оногдуулах ялын төрөл хэмжээг зөвхөн эрүүгийн хуулиар тодорхойлно.<sup>15</sup> Учир нь манай улс эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхийг хориглодог хууль ёсны зарчимтай бөгөөд Эрүүгийн хуулиар 29 зүйлийн 213 гэмт үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцоохор хуульчилсан.

- *Нийгэмд аюултай байх:* Тухайн гэмт хэргийн нийгмийн мөн чанар болоод эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхлын үнэ цэн, ач холбогдол, үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэр, субъектийн хувийн байдал зэргээр тодорхойлогдоно. Тухайлбал, тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний амьд явах эрхэд халдсан үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюул үлэмж их байна. Гэмт хэргийн нийгэмд аюултай байх шинж нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан нийгмийн харилцаа, эрх, ашиг сонирхолд хохирол учирсан, тийм хохирол учрах боломж бодитой бий болсноор илэрч гарна.
- *Гэм буруутай байх:* Энэ нь гэмт хэргийн нэг гол субъектив шинж. Гэмт хэргийн нийгэмд аюултай байх материаллаг шинж шийдвэрлэх ач холбогдолтой боловч гэмт хэргийг гэм буруутай үйлдсэн, өөрөөр хэлбэл, субъект өөрийн үйлдэл, эс үйлдэхүй, тэдгээрийн улмаас үүсэж болох хор уршигт сэтгэл зүйн хувьд хэрхэн хандсаныг заавал тогтоож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар хэд хэдэн хэм хэмжээ манай Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд тусгагдсан байдал.<sup>16</sup> Тухайлбал, Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “... гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр

<sup>15</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 70 дахь тал.

<sup>16</sup> Мөн тэнд.

нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно”, Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлд “Энэ хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон гэм буруутай хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Гэм буруугүйгээр энэ хуульд заасан хохирол, хор уршиг учруулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй”, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлд “...гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэрийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад нотолно” гэж тус тус заасан. Энэ “nulla poena sine culpa” буюу “гэм буруугүй бол ямар ч шийтгэл байхгүй” хэмээх зарчим нь субъектэд хариуцлага оногдуулахдаа заавал гэм бурууг тогтоосон байх шаардлагыг тавихаас гадна ялын хэмжээ гэм буруутай нь тохирсон байхыг шаарддаг. Тийм учраас субъектийн гэм буруугийн байдлыг нарийвчлан тогтоож, түүнийг нотлох шаардлагатай.<sup>17</sup> Гэм буруу нь санаатай болон болгоомжгүй гэсэн хэлбэртэй байх бөгөөд гэм буруугийн агуулга болох ухамсар, хүсэл зориг хэмээх сэтгэл зүйн элементүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх ойлголт юм. Гэм буруугийн хэлбэр нь (i) гэмт зан үйлийг бусад зан үйлээс ялгах хязгаар болдог; (ii) төсөөтэй гэмт хэргүүдийг ялган зүйчлэхэд тус нэмэр болдог; (iii) гэмт хэргийн ангиллын нэг гол шалгуур болохын зэрэгцээ ял оногдуулах, хорих ял эдлэх дэглэмийн төрлийг тодорхойлох нэг үндэслэл болдог; (iv) гэмт хэргийн зүйлчлэлд шийдвэрлэх нөлөө үзүүлэх ач холбогдолтой.

### 1.2.2. Зөрчлийн тухай ойлголт

Жижиг гэмт үйлдэл буюу захиргааны зөрчил нь манай улсад өмнө байсан ойлголт бөгөөд Захиргааны хариуцлагын тухай хуулиар зохицуулагдаж ирсэн. Харин 2017 оноос дээрх үйлдлүүдийг Зөрчлийн тухай хуулиар зохицуулах болсон билээ.

<sup>17</sup> Т.Золбоо, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Гэмт хэргийн бүтээц, УБ., 2018, 6-9 дэх тал.

Үүнтэй холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил нь эрх зүйн ямар салбарт хамаарах талаар эрдэмтэн, судлаачдын дунд нэлээд маргаан өрнөх болсон. Үүнийг тодорхойлоход эхлээд Delict буюу зөрчил гэх ойлголтыг авч үзэх хэрэгтэй бөгөөд үүний дараа эрүүгийн болон захиргааны зөрчлийг ялган зааглах нь зүйтэй юм.

Гэмт хэргээс арай бага аюул бүхий зөрчлийг аюултай бус гэж эрх зүйд авч үздэг.<sup>18</sup> Гэмт хэргийн тухай нэгдмэл нэг тодорхойлолт байдаггүй улс оронд зөрчил нь хариуцлагын үр дагаврыг үүсгэх бүх салбар эрх зүйд хамаарал бүхий ухагдахуун бөгөөд үүнд гэмт хэрэг ч мөн хамаарна. Ийм тогтолцоо бүхий улс оронд хариуцлагын үр дагаврыг үүсгэх бүх үйлдлийг нийтээр нь эрх зүйн зөрчил гэх ойлголтод хамааруулдаг ба үүнийгээ гэмт хэрэг хэмээн үздэг. Харин Монгол Улсын хувьд гэмт хэргийн талаар бие даасан тодорхойлолттой бөгөөд гэмт хэргээс арай аюул багатай эрх зүйн бусад хууль бус үйлдлийг зөрчилд хамааруулж байна. Манай улсад гэмт хэргээс аюул багатай эрх зүйн зөрчил нэлээд олон гардаг бөгөөд тухайн зөрчил ямар салбар эрх зүйд хамаарч байгаагаар нь захиргааны эрх зүйн болон иргэний эрх зүйн зөрчил, сахилгын зөрчил гэх мэтээр ангилдаг.

Харин эрүүгийн зөрчил гэх ойлголт нь улс үндэстэн бүрийн эрх зүйн онцлогоос хамааран өөр өөр утга санааг илэрхийлнэ. Монгол Улс эрүүгийн зөрчлийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй буюу гэмт хэрэг хэмээн тодорхойлдог. Энэ нь гэмт хэргийн нэгдмэл нэг тодорхойлолттой улс орны шинж бөгөөд эрүүгийн зөрчлийг бусад зөрчлөөс онцгойлон тусад нь авч үздэг тогтолцоо юм. Харин эрүүгийн хуульдаа гэмт хэргийн нэгдмэл тодорхойлолтгүй болон эрүүгийн нэгдсэн хуульгүй улс оронд эрүүгийн зөрчил нь дан ганц гэмт хэрэг бус түүнээс өөр, давхар утга санаа агуулж байdag.

Монгол Улсын хувьд гэмт хэрэг гэх нэг ойлголт байх бөгөөд түүнийгээ хөнгөн, хүнд гэсэн ангилалд хуваадаг. Харин Эрүүгийн нэгдсэн хуулттай хэдий ч түүндээ гэмт хэргийн тодорхойлолтгүй

<sup>18</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (2 дахь хэвлэл), УБ., 2008, 49 дэх тал.

улс оронд эрүүгийн зөрчил нь гэмт хэргээс тусдаа гэмт үйлдэл гэх ойлголт үүсэх бөгөөд түүнийгээ гэмт хэрэг, эрүүгийн зөрчил хэмээн ангилдаг.<sup>19</sup> Эрүүгийн нэгдсэн хуульгүй улс оронд эрүүгийн зөрчил гэх ойлголт байх бөгөөд үүнд хариуцлага хүлээх хууль бус бүх үйлдлийг хамааруулан авч үзэж хүнд, хөнгөн гэмт хэрэг, зөрчил, жижиг зөрчил гэсэн ангилалд<sup>20</sup> хуваадаг ажээ.<sup>21</sup>

2017 онд батлагдсан Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар “зөрчил” гэх ойлголтыг хуульчлан гэмт хэрэг, зөрчлийг ялган заагласан үйлдэлд хүлээлгэх хариуцлага хоорондоо уялдаагүйгээс нэг бол эрүүгийн хариуцлага хэмээн ял шийтгэх эсхүл захиргааны хариуцлага хэмээн үзэж хууль болгонд торгох шийтгэл тусгаж ирснийг цэгцэлж, хууль зүйн нэгдсэн бодлоготой болсон юм. Түүнчлэн урьд нь үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан зарим гэмт хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хууль, бусад хуульд заасан захиргааны зарим зөрчил өөр хоорондоо ижил, төстэй байсан бэрхшээлийг шийдвэрлэсэн билээ. Өөрөөр хэлбэл, бусдын өмч хөрөнгөд халдсан нийгмийн хор аюул багатай үйлдэл, нийгмийн хэв журам зөрчсөн, нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан үйлдэл, түүнчлэн дүрэм, журам, норм, стандарт зөрчсөн эсхүл тодорхой нэрлэн заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж авч үзэхээр зохицуулсан.<sup>22</sup>

Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ” гэж заасан. Гэтэл тус зохицуулалтаас үзэхэд ихэнх нь захиргааны байгууллагаас гаргасан дүрэм,

<sup>19</sup> Герман, Австри, Итали, Испани зэрэг улс.

<sup>20</sup> АНУ зэрэг улс..

<sup>21</sup> Т.Золбоо, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Гэмт хэргийн бүтээц, УБ., 2018, 51 дэх тал.

<sup>22</sup> Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, “Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтад хүний эрх, хууль дээдлэх зарчмыг хангах нь” сургалтын гарын авлага, УБ., 2019, 7-8 дахь тал.

журмыг зөрчсөн шинжтэй үйлдэл байна. Эл байдал нь уг хуулийн зохицуулах харилцаа нь захиргааны эрх зүйн харилцаа болохыг харуулна. Зөрчлийн тухай хууль батлагдахаас өмнө захиргааны зөрчлийг Захиргааны хариуцлагын тухай хуулиар зохицуулдаг байсан. Тус хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр буюу тухайн нутаг дэвсгэрт дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны журмыг санаатайгаар болон болгоомжгүйгээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг захиргааны зөрчил гэж үзнэ” гэж заасан. Захиргааны зөрчил нь хууль зүйн дараах шинж агуулсан байдаг.

- *Нийтийн ашиг сонирхлын эсрэг чиглэсэн хор аюултай:* Энэ нь нийтийн ашиг сонирхолд гэм хор учруулж, улмаар иргэдэд сөргөөр нөлөөлдөг.
- *Хууль бус цүл ажиллагаа:* Захиргааны эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдол бүр захиргааны зөрчил болохгүй. Θөрөөр хэлбэл, захиргааны санкцаар захиргааны төдийгүй хөдөлмөрийн, иргэний, газрын гэх мэт бусад салбар эрх зүйн хэм хэмжээг хамгаалсан байдаг. Харин захиргааны зөрчил нь захиргааны шийтгэлээр хамгаалагдсан захиргааны болон бусад салбар эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй юм.
- *Гэм буруутай цүл ажиллагаа:* Энэ нь санаатай буюу болгоомжгүй гэсэн хоёр хэлбэрээр үйлдэгдэнэ. Тухайн этгээд гэм буруутай байх нь захиргааны зөрчлийн хувьд зайлшгүй шинж юм. Хэрэв гэм буруу байхгүй бол захиргааны зөрчил байхгүй гэсэн үг.<sup>23</sup>

Эрх зүйн шинжлэх ухаанд захиргааны эрх зүйд “opportunitätsprinzip”, эрүүгийн эрх зүйд “legalitätsprinzip” зарчим үйлчлэх том ялгаа бий. Тухайлбал иргэн, хуулийн этгээд зөрчил гаргасан бол мэргэжлийн хяналтын улсын байцаагч засах хугацаа өгөөд мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах үүрэгтэй бөгөөд хэрэв зөрчлөө арилгахгүй бол захиргааны шийтгэлийг өөрийн сонголтоор хэрэглэх

<sup>23</sup> П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, УБ., 2016, 356-357 дахь тал.

“opportunitaetsprinzip” зарчим үйлчлэх бөгөөд харин эрүүгийн эрх зүйд гэмт үйлдэл болгонд заавал тохирсон ял оногдуулах “legalitaetsprinzip” зарчим үйлчилнэ.

Хууль санаачлагч Зөрчлийн тухай хууль гаргах болсон үндэслэлээ “зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй ял завшуулж байна” хэмээн тодорхойлон хуулийн зорилгоо “шийтгэл оногдуулах замаар шударга ёсыг тогтооно” хэмээн тунхаглаж, зөрчил гаргасан л бол шийтгэл хүлээлгэхээр хуульчилсан байна. Эндээс Зөрчлийн тухай хууль бол жижиг Эрүүгийн хууль гэдгийг харж болно. Захиргааны эрх зүйн хувьд торгууль бол ял шийтгэл биш юм.<sup>24</sup> Тиймээс ч захиргааны зөрчлийн эрх зүйд “сонгох боломжтой байх зарчим” буюу “principle of opportunity” хэрэгждэгээрээ эрүүгийн эрх зүйгээс ялгаатай хэмээн эх газрын эрх зүйн тогтолцоонд хамаарах орнуудын эрх зүйн онолд үздэг бөгөөд энэ нь Герман, Австри зэрэг орны зөрчлийн хуульд тусгалаа олсон. “Сонгох боломжтой байх зарчим”-ын агуулгад дараах хоёр зүйл хамаардаг. Үүнд:

- Захиргааны зөрчлийг прокурор шалган тогтоох бус, захиргааны байгууллага шалган тогтоох боломжтой байх.
- Зөрчил гаргасан этгээдийг заавал тортож бус, эхний удаад анхааруулан сануулах боломжтой байх.

ХБНГУ-ын Зөрчлийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэ хуулиар прокурор болон шүүгчид харьяалуулаагүй бол захиргааны зөрчлийг шалган тогтооно”, 2 дахь хэсэгт “Энэ хуулиар шүүхэд харьяалуулаагүй бол захиргааны байгууллага зөрчилд хариуцлага хүлээлгэнэ”, 40 дүгээр зүйлд “Хуульд өөрөөр заагаагүй бол прокурор нь гэмт хэргийг шалгах явцад зөрчлийн шинж илэрвэл түүнийг шалган тогтооно”, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ялимгүй шинжтэй зөрчилд захиргааны байгууллага нь 5-55 еврогийн хооронд сануулах шийтгэл оногдуулж болно. Сануулах шийтгэл нь тортгуулийн мөнгөгүй байж болно” гэж;

<sup>24</sup> П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн тусгай ангийн эрх зүйн зохицуулалт ба тулгамдаж буй асуудал, “Эрх зүй” сэтгүүл (Тусгай дугаар II), УБ., 2018, 60 дахь тал.

Австри Улсын Захиргааны шийтгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуулиар тусгайлан харьяалал заагаагүй тохиолдолд нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага зөрчлийг шалган тогтоож, шийтгэл оногдуулна” гэж тус тус “боломжтой байх зарчим”-ыг хуульчилсан байна.

Нэгөөтээгүүр ялимгүй зөрчлүүдийг эрүүгийн эрх зүйгээс тусгаарласан эрх зүйн зохицуулалт бий болгохын нэг гол зорилго нь хуулийн байгууллагын ачааллыг багасгах явдал байдаг бөгөөд зөрчил гаргасан этгээд бүрд шийтгэл ногдуулах нь орчин үеийн хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн Үндсэн хуульт нийгмийн үзэл баримтлалтай нийцэхгүй юм. Иймд зөрчлийн эрх зүйн сонгох боломжтой байх, захиргаа өөрөө бие даан шийдвэрлэх зарчмыг баримталснаар зөрчил үйлдсэн этгээдийн зөрчлийн шинжээс хамаарч захиргааны байгууллагаас тохирох шийтгэл оногдуулах, прокурорын байгууллага, эрүүгийн шүүхийн ачааллыг нэмэгдүүлэхгүйгээр захиргааны байгууллага захиргааны акт гаргасныхаа хувьд бие даан шийдвэрлэх, хэрвээ гэмт хэргийн шинжтэй байгаа бол прокурор руу шилжүүлэх, ингэснээр захиргааны хариуцлагын агуулга, мөн чанар амьдралд бодитоор хэрэгжих нөхцөл бүрдүүлж өгдөг байна.<sup>25</sup>

### 1.2.3. Эрүүгийн болон захиргааны зөрчлийн харилцан хамаарал

Эрүүгийн болон захиргааны эрх зүйн хариуцлагын зорилго, чиг үүргийн ялгааг тодорхойлох асуудал одоо ч улс орнуудад маргаантай судлагдахууны нэг байх бөгөөд Монгол Улс Зөрчлийн тухай хууль батлан гаргаж хэрэгжүүлсэнтэй холбогдуулан эрүүгийн болон захиргааны хууль тогтоомж, түүний хэрэглээнд нөлөөлж буй учир холбогдлыг тодруулж, эрүүгийн болон захиргааны зөрчлийн нийтлэг ба ялгаатай шинжийг тодорхойлох шаардлагатай байна. Тухайлбал, эрүүгийн эрх зүйн болон захиргааны эрх зүйн

<sup>25</sup> Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо, Зөрчлийн тухай хууль болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмж. УБ., 2016, 5-6 дахь тал. [www.legaldata.mn/buteel/pdf?id=177](http://www.legaldata.mn/buteel/pdf?id=177)

хариуцлагыг зорилго, үндэслэлээр нь дараах байдлаар зааглаж болох юм. Үүнд:

### **Хүснэгт 1. Эрүүгийн болон захиргааны зөрчлийн алгаатай байдал**

д/д	Захиргааны	- ХАРИУЦЛАГА -	Эрүүгийн
1	Урьдчилан сэргийлэх	Зорилго	Шийтгэх
2	Хамгаалах (ирээдүйн үйлдэлд чиглэсэн)	Үндэслэл	Нэхэн залруулах (өнгөрсөн үйлдэлд чиглэсэн)
д/д	Захиргааны	- ЗӨРЧИЛ/ГЭМТ ХЭРЭГ -	Эрүүгийн
1	Нийтлэг эрхэд халтай өндөр эрсдэл үүсгэх	Халдлагын зүйл	Нийтлэг эрхийг үгүйсгэх
2	Эрх чөлөөг хязгаарлах	Шийтгэлийн шинж байдал (натур)	Эрх чөлөөг нь үгүйсгэх/яллах

Гэмт хэрэг нь үйлдэгчийн субъектив санаа зорилгоор тодорхойлогддог бол захиргааны зөрчил нь объектив эрсдэлээр хэмжигддэг. Тиймээс захиргааны хариуцлага хүлээлгэх нөхцөл нь өндөр эрсдэл үүсэж болзошгүй байгаа эсэхээс, эрүүгийн хариуцлага нь гэмт үйлдэл хийх санаа зорилго байсан эсэхээс шалтгаална.

Эрүүгийн хариуцлага нь шүүгдэгчийн өөрийнх нь эрхийг үгүйсгэх буюу яллах шинжтэй бол захиргааны хариуцлага нь эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарлахаас биш, шууд үгүйсгэдэггүй.

Захиргааны хариуцлагын хувьд хуулийн хэрэгжилтийг хангуулахаар зорьж буй зүйл нь эрүүгийн хэргийн нэгэн адил нэгэнт үйлдэгдсэн хор хохирлыг нөхөж залруулах (ex post) биш харин олон нийтэд халтай, болзошгүй өндөр эрсдэлээс урьдчилан сэргийлэх (ex ante) явдал ажээ. Учир нь эрүүгийн эрх зүй шийтгэх, харин захиргааны эрх зүй урьдчилан сэргийлэх (deferrence) зохицуулалтын аргаар тухайн салбар эрх зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж байдаг. Тиймээс захиргааны хариуцлагын зорилго нь шийтгэхээс илүүтэйгээр олон нийтэд халтай эрсдэл

бүхий зөрчлөөс хяналт шалгалт хийх замаар сэргийлснээр нийтлэг эрхийг урьдчилан хамгаалах зорилготой.<sup>26</sup>

Мөн Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагын төрлийг харвал эрүүгийн эрх зүйн салбарт хамаарна гэж дүгнэж болохоор байна. Учир нь хүний жам ёсны эрхийг хязгаарлаж болох баривчлах ялыг хуульчилсан. Үүнд тулгуурлан эрүүгийн эрх зүйн салбарт хамаарна хэмээн үзвэл эрх зүйн тогтолцооны томоохон асуудал урган гарч ирнэ. Учир нь Монгол Улс шиг нийгмийн харилцааг төрөлжүүлэн нэгтгэсэн хуулиар зохицуулдаг улсад эрүүгийн гэмт хэргийг хоёр хуулиар зохицуулах тохиолдолд гэмт хэргийн ойлголт, онцлог тодорхойгүй болохын дээр Эрүүгийн хуулийг Зөрчлийн хуулттай төсөөтэй хэрэглэх нөхцөл бий болно. Энэ нь эрүүгийн эрх зүйн тогтолцооны маш том согогийг бий болгож иргэдийн эрх ашигт сөргөөр тусах магадлалтай.<sup>27</sup> Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зохицуулалт Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалтаас хэрхэн ялгагдаж байгаа нь тодорхой бус байна.<sup>28</sup>

Эх газрын эрх зүйн тогтолцоотой орны хувьд захиргааны зөрчил нь эрүүгийн зөрчил буюу гэмт хэрэгтэй төстэй байх ганцхан зүйлтэй. Тодруулбал, гэмт хэрэг нь эрүүгийн эрх зүйн үүднээс эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй, түүндээ гэм буруутай байсан гэсэн бүтээцтэй байдаг. Захиргааны зөрчил нь онолын хувьд дээр дурдсан гэмт хэргийн бүтээцийн хувьд яг ижил. Учир нь дүрэм, журмын зөрчил нь эрүүгийн гэмт хэргийн адил хариуцлагын үр дагавар үүсгэж байдаг тул заавал хуульд заасан, мөн түүндээ гэм буруутай байх шинжийг агуулах учиртай.<sup>29</sup>

<sup>26</sup> Ц.Цогт, Захиргааны хэргийн шүүх, УБ., 2019, 53-54 дэх тал.

<sup>27</sup> Т.Золбоо, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Гэмт хэргийн бүтээц, УБ., 2018, 11-12 дахь тал.

<sup>28</sup> Энэ талаар дараагийн бүлэгт дэлгэрэнгүй авч үзэх болно.

<sup>29</sup> Т.Золбоо, Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги, Гэмт хэргийн бүтээц, УБ., 2018, 12-13 дахь тал.

**Хүснэгт 2. Эрүүгийн болон захиргааны зөрчлийн  
нийтлэг байдал**

Д/д	Гэмт хэргийн бүтээц	Захиргааны зөрчлийн бүтээц
1	Эрүүгийн хуульд заасан	Захиргааны хуульд заасан
2	Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүй	Дүрэм, журам зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй
3	Гэм буруу	Гэм буруу
4	Хариуцлага	Хариуцлага

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд Монгол Улсад “зөрчил” гэх ойлголт 2017 онд Зөрчлийн тухай хууль батлагдаж, хэрэгжсэнээс хойш бий болсон хэдий ч энэ нь салбар эрх зүйн зөрчилдөөнийг үүсгэсэн. Учир нь зөрчил гэж юу болох, ямар онцлог шинжтэй эсэхийг тодорхойлж чадаагүйгээс үүдэн салбар эрх зүй судлаач, эрдэмтдийн дунд одоо хүртэл маргаан өрнөсөөр байна. Зарим судлаач, эрдэмтэд эрүүгийн болон захиргааны зөрчлийн харилцан хамаарал, нийтлэг болон ялгаатай шинжийг тодорхойлсон байгаа нь энэхүү судалгааг хийхэд чухал ач холбогдолтой байлаа.

# **ХОЁР. ГЭР БУЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ПРАКТИК АСУУДАЛ**

## **2.1. ГЭР БУЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **2.1.1. Олон улсын баримт бичиг**

Хүн амьдарч буй орчин, гэр бүлдээ айх аюулгүй, аливаа хүчирхийлэл, дарамтаас ангид байх эрхийг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүүхдийн эрхийн тухай конвенц, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women, 1979)<sup>30</sup>, түүний нэмэлт протокол, Эхчүүдийг хамгаалах тухай конвенц<sup>31</sup> (Maternity Protection Convention, 2000), Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг устгах тухай тунхаглал<sup>32</sup> (Declaration on the Elimination of Violence against Women, 1993), Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хууль<sup>33</sup> (A framework for model legislation on domestic violence, 1996) зэрэг олон улсын баримт бичигт баталгаажуулсан билээ.<sup>34</sup> Мөн Эмэгтэйчүүдийн асуудлаарх олон улсын дөрөвдүгээр бага хурлаар Бээжингийн тунхаглал<sup>35</sup> (Beijing Declaration and Platform for Action, 1995) батлан улс орон, төрийн болон төрийн бус байгууллагууд энэ төрлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх,

<sup>30</sup> <https://www.ohchr.org/en/professionalinterest/pages/cedaw.aspx>

<sup>31</sup> [https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100\\_ILO\\_CODE:C183](https://www.ilo.org/dyn/normlex/en/f?p=NORMLEXPUB:12100:0::NO::P12100_ILO_CODE:C183)

<sup>32</sup> <https://www.ohchr.org/en/professionalinterest/pages/violenceagainstwomen.aspx>

<sup>33</sup> <http://hrlibrary.umn.edu/commission/thematic52/53-add2.htm>

<sup>34</sup> Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи судалгааны тайлан (2018-2020), УБ., 2021, 31 дэх тал.

<sup>35</sup> <https://www.un.org/womenwatch/daw/beijing/pdf/BDPfA%20E.pdf>

түүнийг шийдвэрлэхийн тулд авах арга хэмжээг тус баримт бичигт жагсаасан.<sup>36</sup>

Дээрх бичиг баримтуудаас гадна Европын Зөвлөлийн Сайд нарын хороо (Committee of Ministers of the Council of Europe)-ноос Эмэгтэйчүүдийг хүчирхийллээс хамгаалах тухай зөвлөмж<sup>37</sup> (Recommendation on the protection of women against violence, 2002) баталж, үүний дараа Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай конвенц буюу Станбулын конвенц<sup>38</sup> (Convention on preventing and combating violence against women and domestic violence, 'Istanbul Convention')-ыг тус тус баталсан байх бөгөөд тус Конвенц нь 2014 онд хүчин төгөлдөр болсон юм. Тус Конвенцын 3-р зүйлийн b-д гэр бүлийн хүчирхийлэл гэж "гэр бүл өсхүл гэр бүлийн нэгж доторх, өсхүл өмнөх болон одоогийн эхнэр/нөхөр, хамтрагчдын хооронд болсон, хүчирхийлэл үйлдэгч нь хохирогчтой нэг орон байранд хамт амьдардаг өсхүл тийм байсан эсэхээс үл хамааран гаргасан бие махбодын, бэлгийн, сэтгэл зүйн өсхүл эдийн засгийн бүхий л хүчирхийлсэн үйлдлийг ойлгоно" хэмээн тодорхойлжээ.

Хүүхдийн эрхийн тухай конвенцын 19 дүгээр зүйлд<sup>39</sup> "Оролцогч улсууд эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, хүүхдийг асран халамжилж байгаа бусад хүн хүүхдийг бие бялдар, сэтгэл зүйн хувьд бүхий л хэлбэрээр дарамтлах, доромжлох, сөргөөр ашиглах, хайр халамжгүй орхих, зүй бусаар хандах, хэрцгийгээр харилцах, албадан хөдөлмөрлүүлэх буюу бэлгийн хүчирхийлэл үйлдэхээс хамгаалах зорилгоор хууль тогтоох, захирагааны, нийгмийн болон гэгээрлийн бүхий л шаардлагатай арга хэмжээ авна. Хамгаалалтын арга хэмжээ нь хүүхэд, тэднийг асран халамжилдаг хүмүүст шаардлагатай тусlamж үзүүлэх зорилгоор нийгмийн хөтөлбөр боловсруулах, түүнчлэн хүүхдэд хэрцгийгээр хандахаас урьдчилан

<sup>36</sup> [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2019/644190/EPRS\\_BRI\(2019\)644190\\_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2019/644190/EPRS_BRI(2019)644190_EN.pdf)

<sup>37</sup> [https://www.coe.int › Source › rec2002\(5\)\\_en](https://www.coe.int › Source › rec2002(5)_en)

<sup>38</sup> <https://rm.coe.int/168008482e>

<sup>39</sup> [www.legalinfo.mn/law/details/1276?lawid=1276](http://www.legalinfo.mn/law/details/1276?lawid=1276)

сэргийлэх, илрүүлэх, мэдээлэх, авч хэлэлцэхээр шилжүүлэх, мөрдөн байцаалт явуулах, эмчлэх, шаардлагатай тохиолдолд шүүх ажиллагаа явуулах болон бусад арга хэмжээг тусгасан журмыг агуулна” гэж хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах асуудлыг зохицуулсан.

Мөн Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын 1 дүгээр зүйлд<sup>40</sup> “Энэхүү конвенцын зорилгоор эмэгтэйчүүдийг алагчлах гэсэн нэр томьёо нь гэрлэлтийн байдлаас үл хамаарч эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн үндсэн дээр улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, иргэний болон аливаа бусад салбарыг эмэгтэйчүүдийн үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, эдлүүлэх, хэрэгжүүлэхэд саад хийх эсхүл үгүйсгэх үр дагавар, зорилго бүхий хүйсээр ялгаварлах, үгүйсгэн гадуурхах буюу хязгаарлахыг хэлнэ” хэмээн эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах тухай ойлголтыг тусгасан.

Мөн Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай тунхаглал<sup>41</sup> (Declaration of Basic Principles of Justice for Victims of Crime and Abuse of Power, 1985)-д “хохирогч” гэдгийг “Гишүүн орнуудын хүчин төгөлдөр үйлчилж буй эрүүгийн хуулийг зөрчсөн гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие махбодын гэмтэл авсан, сэтгэцийн гэмтэл, сэтгэл санааны дарамтад орсон, санхүүгийн алдагдал хүлээсэн, үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн, гарз хохирол учирсан бие хүн болон хамт олныг ойлгоно” хэмээн тодорхойлоод гэмт этгээд гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон, баривчлагдсан, шүүх хэргийг хянан шийдвэрлэсэн эсэхээс болон хохирогчтой гэр бүл, хамаатан садны харилцаатай эсэхээс үл шалтгаалан хохирсон этгээд, түүний гэр бүлийн гишүүд, халамжид нь байгаа хүмүүсийг хохирогч гэж үзэн хохирогчоор тогтоох тухай тусгасан байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн улмаас зөвхөн хохирогч бус түүний гэр бүл, ойр дотнын хүмүүст хохирол

<sup>40</sup> [www.legalinfo.mn/law/details/1285?lawid=1285](http://www.legalinfo.mn/law/details/1285?lawid=1285)

<sup>41</sup> <https://www.ohchr.org/en/professionalinterest/pages/victimsofcrimeandabuseofpower.aspx>

учирдаг тул бүгдэд нь нөхөн олговор болон нөхөн төлбөр олгох асуудлыг авч үзсэн.

Улс орнуудыг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай тусгайлан хууль тогтоомж боловсруулан гаргах, үндэсний хууль тогтоомжоо сайжруулахыг уриалж 1996 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай” загвар хуулийг НҮБ-аас боловсруулан гаргасан юм. Тус загвар хууль нь гэр бүлийн гишүүд буюу ойр дотно харилцаатай хүмүүсийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн бол гэр бүл дэх хүчирхийлэл гэж үзэж, хүйсийн өвөрмөц байдлыг тусгасан, тодорхой нэр заасан хүмүүсийг хүчирхийлэхийг хориглосон, хүчирхийллийн хохирогчдыг хамгаалсан, хүчирхийлэл дахин гараггүй байхад чиглэсэн зэрэг хүчирхийлэлтэй холбоотой бүх асуудлыг багтаасан.

Тус хуулиар гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: “Хүйсийн ялгаатай байдлыг үндэслэн гэр бүлийн эмэгтэй гишүүний эсрэг үйлдсэн бие махбод, сэтгэлзүйн болоод бэлгийн харилцааны шинжтэй; хэл амаар доромжлохоос эхлээд бие махбодод хүнд гэмтэл учруулах, хулгайлах, бэртээж гэмтээхээр заналхийлэх, айлган сүрдүүлэх, албадах, мөрдөн мөшгөх, орон байранд хүчээр буюу хууль бусаар нэвтрэн орох, өмч хөрөнгө устгах, бэлгийн хүчирхийлэл, хүчээр гэр бүл болох, инж, сүй буюу төлөөстэй холбоотой хүчирхийлэл, бэлэг эрхтнийг бэртээж гэмтээх, биенийг нь үнэлэхтэй холбоотой хүчирхийлэл, гэрийн үйлчлэгчийг хүчирхийлэх хүртэлх хүчирхийллийн шинжтэй бүх үйлдэл, мөн тийм үйлдэл хийх оролдлогыг гэр бүл дэх хүчирхийлэл гэж үзэх ёстой” гэжээ.

Процессын хувьд нэг зүйлийг онцлон тэмдэглэхэд, гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг прокурор тодорхойлохдоо зөвхөн нотлох баримт үнэлэгдэхгүй байна гэх үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож болохгүй буюу хохирогчийн мэдүүлэг хүчирхийлэгчийг яллагдагчаар татахад хангалттай байх зарчмыг баримтлахаар заасан.<sup>42</sup> Мөн, шүүгдэгч анх удаа гэр бүлийн хүчирхийллийн

<sup>42</sup> Загвар хуулийн 5 дахь хэсгийн 4 дүгээр зүйл.

хөнгөн гэмт хэрэгт холбогдож, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн зэрэг тохиолдолд хохирогчийн зөвшөөрлийг үндэслэн түүнийг хамгаалалтад байлагах захирамж гарган, шүүгдэгчийн хорих ялыг хойшлуулах боломжтой.<sup>43</sup> Харин уг гэмт хэргийг давтан үйлдсэн, бие махбодод хүнд гэмтэл учруулсан, галт зэвсэг болон зэвсгийн чанартай эд зүйл ашигласан бол ял шийтгэлийг хүндруүлэх нь зүйтэй болохыг дурджээ.<sup>44</sup>

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай загвар хуулийн зорилгод “гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой бүх хууль тогтоомж нь хохирогчдыг бие махбод, бэлгийн хүчирхийлэл төдийгүй сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн аливаа тохиолдолд үзүүлж болох хамгийн дээд хамгаалалтаар хангах”<sup>45</sup> гэж, гомдол гаргах журам хэсэгт “цагдаагийн ажилтан нь хохирогч болон түүний хамаарал бүхий хүмүүсийн аюулгүй байдлыг хангахын тулд бүхий л боломжит арга хэмжээг авах ёстой”<sup>46</sup> гэж заасан ба эрүүгийн болон иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангахын ач холбогдлыг чухалчлан тэмдэглэсэн. Тухайлбал, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул заналхийлж, шүүхийн шийдвэр гарах хүртэл аюултай байх нөхцөл байдалтай байгаа бол хохирогч/нэхэмжлэгч, хамаатан садан, халамжийн ажилтан нь хүчирхийлэл үйлдэгдсэнээс хойш 24 цагийн дотор хүчирхийлэл үйлдэгчийн эсрэг түр тусгаарлах тогтоол гаргуулах<sup>47</sup> зэрэг яаралтай хамгаалуулах тусlamж үзүүлэх хүсэлтийг шүүхэд гаргаж болохоор зохицуулсан байна. Мөн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед “шүүхийн шатанд гэр бүлийн хүчирхийлэлд буруутгагдаж буй холбогдогч хохирогчтой цагдаагийн ажилтны хяналтгүйгээр

<sup>43</sup> Загвар хуулийн 5 дахь хэсгийн 10 дугаар зүйл.

<sup>44</sup> Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн ерөнхий газар, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн криминологи судалгааны тайлан (2018-2020), УБ., 2021, 33 дахь тал.

<sup>45</sup> Загвар хуулийн 1 дэх хэсгийн (f) заалт.

<sup>46</sup> Загвар хуулийн 3 дахь хэсгийн (С) зүйлийн (d) заалт.

<sup>47</sup> Загвар хуулийн 4 дэх хэсгийн (А) зүйлийн 3 дахь заалт.

харилцахгүй байх ёстой”<sup>48</sup> гэсэн бол “гэрлэлт цуцлуулах, нөхөн төлбөр олгох тухай иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байх үед хохирогч хамгаалалт авах хүсэлт гаргасан бол энэ тухай хүсэлтийг иргэний хэргээс тусад нь авч шийдвэрлэнэ”<sup>49</sup> гэж заажээ.

Тус загвар хуулиас мөн онцлох нэг зүйл нь, гэр бүлийн хүчирхийллийг зөвхөн эрх зүйн тогтолцоонд үр дүнтэй шийдвэрлэх боломжгүй нарийн төвөгтэй харилцаа гэж үздэг тул цагдаа, прокурор, шүүхийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагуудыг тусгахаас гадна гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод яаралтай болон урт хугацааны тусламж үзүүлэхийн тулд шүүх, цагдаа, тусгай үүргийн ажилтан зэрэг хууль зүйн мэргэжилтнүүд, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, зөвлөхийг гэр бүлийн хүчирхийллийн асуудалд нарийвчлан бэлтгэж сургах тухай<sup>50</sup> зохицуулалт агуулсан байна.

### **2.1.2. Монгол Улсын хууль тогтоомж**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудал нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Гэр бүлийн тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиуд, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр зэрэг хууль тогтоомжоор зохицуулагдаж байна.

Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт “...гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. ...Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална”, 14 дэх хэсэгт “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, ...эрхтэй” гэж гэр бүлийн харилцааг хуулиар

<sup>48</sup> Загвар хуулийн 5 дахь хэсгийн 6 дугаар зүйл.

<sup>49</sup> Загвар хуулийн 6 дахь хэсгийн 1 дүгээр зүйл.

<sup>50</sup> Загвар хуулийн 7 дахь хэсгийн Е зүйл.

хамгаалах, гэр бүлийн гишүүд аливаа хүчирхийллээс ангид байх, хүчирхийлэлд өртвөл хэрхэн хамгаалуулах талаар зохицуулсан.

Улмаар УИХ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 2004 онд баталж, 2016 онд тус хуулийг дахин шинэчлэн найруулсан. Тус хуулиар гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоож, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоохтой холбоотой харилцааг зохицуулахаар заасан. Мөн гэр бүлийн хүчирхийлэл гэж юу болох, хэн хамаарах, гэр бүлийн хүчирхийллийн хэлбэр ямар байх, хохирогчийн эрхийг хэрхэн хангах, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тогтолцоо ямар байх, хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоож ямар арга хэмжээг авах, эрсдэлийн үнэлгээ хийх, хохирогчид үйлчилгээ үзүүлэх, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих зэрэг асуудлуудыг тусгасан.<sup>51</sup> Тус хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан 2002 оны Эрүүгийн хуулийн 120<sup>1</sup> дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хуулийн 221 дугаар зүйлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил хэмээн нэмэгдсэн байсныг 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг бие даасан гэмт хэрэг<sup>52</sup> гэж үзэхийн зэрэгцээ тодорхой төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн<sup>53</sup> болгон хуульчилсан байна. Мөн 2017 онд Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн үйлдлийг зөрчил хэмээн зохицуулсан.

<sup>51</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 1 дүгээр зүйл. [www.legalinfo.mn/law/details/12393?lawid=12393](http://www.legalinfo.mn/law/details/12393?lawid=12393)

<sup>52</sup> Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл. [www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634](http://www.legalinfo.mn/law/details/11634?lawid=11634)

<sup>53</sup> Эрүүгийн хуулийн 11.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 11.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 12.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт.

## 2.2. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ПРАКТИК АСУУДАЛ

2015 оны Эрүүгийн хууль, 2017 оны Зөрчлийн тухай хуулийг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс даган мөрдөж өхэлсэн бөгөөд дээрх хуулиудад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх асуудлыг ялган зааглаж, оновчтой томьёолж чадаагүйн улмаас мөрдөгч, прокурор, шүүх хуулийн агуулгыг янз бүрээр тайлбарлан, ялгамжтай шийдвэр гаргах болсон байна.

### 2.2.1. Нэр томьёоны асуудал

“Гэр бүлийн хүчирхийлэл”-ийг ойлгохын тулд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиас гадна Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудын нэр томьёо зайлшгүй чухал юм. Гэтэл дээрх хууль тус бүрд дараах нэр томьёог өөр өөр утгаар тайлбарлажээ. Үүнд:

- 1) *Объектив шинж*: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэдгийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд “энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхүй”<sup>54</sup> гэж; Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, харгис хэрцгий харьцсан, догшин авирласан, тарчлаасан, эд хөрөнгө захиран зарцуулах эрхэд халдсан үйлдэл, эс үйлдэхүй” гэж; Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4-т “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, эд хөрөнгө захиран зарцуулах эрхэд халдсан үйлдэл, эс үйлдэхүй” гэж тус тус заажээ. Үүнээс харахад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан сэтгэл санаа, эдийн засаг, бэлгийн болон бие махбодын хүчирхийллийн объектив

<sup>54</sup> Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт.

шинжийг Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд бүрэн хуульчилж чадсан эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал, хараалын үг хэрэглэх, бүдүүлэг харилцах, хардах, айлгах, сүрдүүлэх, дорд үзэх, загнах, буруутгах, үл хайхрах, мөрдөн мөшгөх, заналхийлэх, гутаан доромжлох зэрэг сэтгэл санааны хүчирхийлэл<sup>55</sup>, орлого олох боломжийг хязгаарлах, эдийн засгийн эрх мэдэлгүй болгох, шаардлагатай хэрэгцээг хясан боогдуулах, тэжээн тэтгэхээс зайлсхийх, гачигдуулах зэрэг эдийн засгийн хүчирхийлэл<sup>56</sup> дээрх хуулиудад бүрэн тусаагүй. Гэхдээ бусад гэмт хэргийн<sup>57</sup> хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан гэр бүлийн хүчирхийллийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хүчирхийллийн хэлбэрийн дагуу тайлбарлан шүүх шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл болон Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт үйлдлийн арга бүрийг тоочин заасан нь хийдэл үүсгэсэн.

- 2) **Хохирогч:** Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нь “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн” байхаар Эрүүгийн хуулийн тусгай анги (цаашид ЭХТА гэх)-ийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэх холбогдох зүйлүүдэд тодорхойлсон. Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн гэдгийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлд өргөжүүлэн тодорхойлсон.<sup>58</sup> Мөн

<sup>55</sup> НҮБ-ын Хүн амын сан, Швейцарын хөгжлийн агентлаг, Хүйсийн тэгш эрхийн төв, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нийгмийн ажилтнуудад зориулсан гарын авлага, УБ., 2018, 12-13 дахь тал.

<sup>56</sup> Мөн тэнд.

<sup>57</sup> ЭХТА-ийн 10.1.2.8, 10.4.1, 11.1.2.1, 11.4.2.1, 11.6.2, 12.1.2.3 дахь заалт.

<sup>58</sup> эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалzan дэмжигч, тэдгээрийн асрамж хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;

- тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү;
- гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд.

ЭХТА-ийн 10.4 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт арай өөр байдлаар тайлбарласан.<sup>59</sup> Гэтэл Гэр бүлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд гэр бүл, гэр бүлийн гишүүн, төрлийн болон садны хүн гэсэн нэр томьёо байхаас биш гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, гэр бүлийн харилцаатай хүн, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн гэх ойлголт байхгүй. Өөрөөр хэлбэл, аль хуулийн нэр томьёог үндэслэж хохирогчийг тодорхойлох нь эргэлзээтэй болсноос гадна дээрх хуулиудын уялдааг хангаж чадаагүй байна.

### 2.2.2. Хэргийн зүйлчлэлийн асуудал

ЭХТА-ийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх)-ийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив шинж болон Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих)-ийн 4 дэх хэсэгт заасан зөрчлийн хэргийн бүрэлдэхүүний объектив шинжийг Хүснэгт 3-т үзүүлснээр тодорхойлсон.

#### *Хүснэгт 3. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн ижил төстэй зохицуулалтыг харьцуулсан байдал*

д/д	Эрүүгийн хууль	Зөрчлийн тухай хууль	Тайлбар
	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг		Ижил
	Байнга	-	Өөр
1	Зодсон	Зодсон	Ижил
2	Харгис хэрцгий харилцсан, догшин авирласан, тарчлаасан	Хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан Бусадтай харилцахыг хязгаарласан	Ойролцоо

<sup>59</sup> гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүн.

## Хүснэгт 3-ын цргэлжлэл

3	Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	Хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан	Ижил
---	---	---	------

д/д	Хариуцлага	Тайлбар
1	Албадлагын арга хэмжээ	Албадлагын арга хэмжээ
2	6 сараас 1 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хорих ял	7-гоос 30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл

Хүснэгт 3-аас үзвэл гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан бол гэмт хэрэг, зөрчлийн алинаар авч үзэх нь тодорхойгүй болох хүндрэл үүсгэсэн. Ганцхан зааглаж буй томьёолол нь БАЙНГА гэдэг шинж юм. Үүнийг хэрхэн ойлгох вэ?

- Академич С.Нарангэрэл “...янз бүрийн объектив, субъектив нөхцөл байдалд цаг хугацааны нэлээд завсарлагатайгаар нэг гэмт хэргийг хоёроос дээш удаа үйлдэх нь гэм буруутай этгээдийн үйлдлийг байнга гэж үзэх үндэс болохгүй. Байнга гэдэг бол гэмт хэрэг үйлдэх явдал үе үе давтагдаж, тэдгээрийн хоорондын зайд их бишийг харуулан гэм буруутай этгээдийн зан үйлийн тодорхой чиглэл илэрсэн, гэмт хэрэг давтан үйлдэх явдал юм. Гурав буюу түүнээс дээш гэмт хэрэг үйлдэх нь байнга гэсэн ухагдахууны зайлшгүй тоон үзүүлэлт мөн”;
- Доктор С.Жанцан “...нэг этгээд нэлээд үргэлжилсэн хугацаанд нэг гэмт хэргийг дөрөв ба түүнээс дээш удаа үйлдэж, тэдгээрийн алинд нь ч шийтгэгдээгүй бөгөөд энэ нь түүний гэмт зан төлөвийн тогтсон хандлагыг илэрхийлсэн байхыг гэмт хэргийг байнга үйлдэх гэнэ”;

- Улсын Дээд шүүхийн 2010 оны 13 дугаар тогтоолд<sup>60</sup> “...хуулийн 100 дугаар зүйлийн 100.1-д заасан “байнга зодох” гэж тодорхой нэг хохирогчийн эсрэг чиглэсэн, хэвшмэл маягтай, гурав ба түүнээс дээш удаа бие махбодын хүчирхийлэл хийсэн байхыг хэлнэ” гэж тус тус тодорхойлжээ.

Дээрхээс байдлаас дүгнэж үзэхэд “байнга гэмт хэрэг үйлдэх” гэх ойлголт нь:

- Нэг гэмт хэргийг тодорхой хугацааны завсарлагатайгаар гурав ба түүнээс дээш удаа үйлдсэн байх;
- Тэдгээрийн алинд ч ял шийтгүүлээгүй байх;
- Гэмт хэрэг үйлдсэн хүний гэмт зан төлөвийн илрэл бөгөөд энэ нь амьдралд нь хэвшиж тогтсон дадал зуршил гэсэн шинж агуулж байна.<sup>61</sup>

Гэтэл шүүх ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон гэх объектив талын үндсэн шинжийг дараах байдлаар тайлбарлан хэрэглэж буй нь хууль хэрэглээний хувьд зөрчилтэй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Тухайлбал, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1891 дүгээр цагаатгах тогтоолоор<sup>62</sup> дараах шийдвэрийг гаргасан. Үүнд: “... шүүгдэгч Г.Г нь согтуурсан үедээ буюу 2018.05.09-ний өдөр, 2018.11.09-ний өдөр болон 2019.10.05-ны өдрүүдэд өөрийн гэртээ гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох эхнэр Ж.А-гийн үснээс нь зулгааж, өшиглөж зодсон гэх гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт холбогдсон. Шүүгдэгч Г.Г-гийн 2018.05.09-ний өдөр болон 2018.11.09-ний өдрийн үйлдэлд нь Зөрчлийн тухай хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэсэн үндэслэлээр 2018.05.11-ний өдрийн 769 дүгээр, 2018.11.12-ны өдрийн 1700 дугаар шүүхийн шийтгэврээр тус тус зөрчлийн шийтгэл оногдуулсан байна.

<sup>60</sup> <https://legalinfo.mn/mn/detail/663>

<sup>61</sup> <https://mglbar.mn/news/3307>

<sup>62</sup> <http://new.shuukh.mn/eruuhan/39410/view>

*Анхан шатны шүүх:* Шүүгдэгчид хамгийн сүүлд оногдуулсан шийтгэлээс хойш 11 сарын хугацаа өнгөрсөн байх тул Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд зааснаар хөөн хэлэлцэх хугацаа дууссан байна. Ийнхүү зөрчлийн хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан байнга гэх шинж үгүйсгэгдэж байна. Мөн нөгөөтээгүүр үгийн утга, агуулгын хувьд байнга гэх шинж нь нэг үйлдлийг олон удаа ойр ойрхон хийхийг ойлгохоос бус нэг үйлдлийг хугацааг нь харгалзахгүйгээр 3 ба түүнээс дээш удаа хийсэн байна гэж ойлгох нь өрөөсгөл болж байна. Шүүгдэгч Г.Г нь 2019.10.05-ны өдөр гэр булийн хамаарал бүхий харилцаатай хүн болох өөрийн эхнэр Ж.А-гийн үснээс нь зулгааж, өшиглөж зодсон нь нэг удаагийн үйлдэл болох бөгөөд энэ нь гэр булийн хүчирхийллийн шинжийг агуулсан боловч давтамжийн хувьд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан “байнга” гэх шинжийг хангахгүй болно. Иймд шүүгдэгч Г.Г нь гэр булийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг байнга үйлдсэн нь тогтоогдохгүй байх тул түүнд холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгах үндэслэлтэй байна” гэжээ.

Харин Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 184 дүгээр магадлалаар “Шүүгдэгч Г.Г нь 2019.10.05-ны өдөр эхнэр Ж.А-г зодсон болох нь тогтоогдсон хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг 1.1 дэх заалтад заасан гэмт хэргийн шинжийг хангахгүй байна. Өөрөөр хэлбэл, шүүхээс зохих зөрчлийн хариуцлага хүлээсэн 2018.05.09 болон 2018.11.09-ний өдрийн үйлдлийг нь сүүлийн 2019.10.05-ны өдрийн үйлдэлтэй холбож, гэр булийн хүчирхийллийг байнга үйлдсэн гэж дүгнэх хууль зүйн боломжгүй, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн шударга ёсны зарчимтай харшлах юм” гэж дүгнэсэн.

Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхлэхэд шүүх ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр булийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Зөрчлийн

тухай хуулийн 5.4 дүгээр зүйлд заасан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчлөөс “байнга” гэх шинжээр ялгаж байсан бөгөөд шийдвэр гаргахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий анги (цаашид ЭХЕА гэх)-ийн 1.3 дугаар зүйлийн 5-д заасан “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах” шударга ёсны зарчмыг баримталж байсан. Өөрөөр хэлбэл, шүүх гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээд тухайн үйлдэлдээ Зөрчлийн тухай хуулиар шийтгэгдсэн бол шударга ёсны зарчмын дагуу тэрхүү үйлдэлдээ дахин эрүүгийн хариуцлага хүлээхгүй байхаар шийдвэрлэсэн байдал. Үүнээс болж хохирогч гурав болон түүнээс дээш удаа гэр бүлийн хүчирхийлэлд өртсөний дараа гомдол, мэдээлэл гарган хүчирхийлэл үйлдсэн этгээдэд Эрүүгийн хуулиар ял шийтгүүлэх үү, эсхүл тухай бүрд нь гомдол, мэдээлэл гаргаад Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулах уу гэсэн нөхцөл байдал бий болсон нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндсэн зорилгод нийцэхгүй байсан.<sup>63</sup> Үүнтэй холбоотойгоор нэг талаас гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн хохирдог, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших нөхцөл байдал үүссэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой гэмт хэрэг, зөрчил шийдэгдэж байгаа тоон мэдээллийг Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллаганаы сүүлийн дөрвөн жилийн шүүхийн тайлангаас авч үзвэл тогтмол өссөн үзүүлэлт харагдаж байна.

<sup>63</sup> Монголын криминологичдын холбоо, Монгол Улсад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх нь, УБ., 2020, 7-9, 37-39 дэх тал (Монголын Криминологичдын Холбооноос гаргасан энэхүү судалгааны тайлангаар дээрхтэй адил дүгнэлт хийсэн байна).

*Хүснэгт 4. Анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэрэг, зөрчил*

Гэмт хэрэг (Анхан шатны шүүх)						
д/д	Утга	2017 он <sup>64</sup>	2018 он <sup>65</sup>	2019 он <sup>66</sup>	2020 он <sup>67</sup>	
1	Нийт шийдвэрлэсэн хэрэг	8839	12551	13427	13470	
2	Гэм буруутайд тооцсон хүн	10040	14925	15366	15964	
3	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэрэг	59	115	210	101	
4	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүн	33	73	176	67	

Зөрчлийн хэрэг (анхан шат)				
д/д	Утга	2017 он	2018 он	2019 он
1	Нийт шийдвэрлэсэн хэрэг	12669	12956	17629
2	Гэм буруутайд тооцсон хүн	12669	12901	17990
3	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх хэрэг	-	4239	7134
4	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүн	-	4270	7178

Хүснэгт 4-өөс харахад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн тоо хоёр дахин нэмэгдсэн хэдий ч нийт гэмт хэрэгт эзлэх хувийн жин бага байгаа бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийн хэрэг жил тутам хоёр дахин нэмэгдэхийн зэрэгцээ нийт зөрчлийн хэргийн 1/3 хувийг эзэлж байна. Үүнээс гадна 2018–2019 онд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг нь зөрчлийн хэргийн дөнгөж 2.7-2.9 хувийг эзэлж байсан нь ЭХТА-

<sup>64</sup> Монгол Улсын шүүхийн тайлан (2017 он). [http://www.judcouncil.mn/site/news\\_full/7022](http://www.judcouncil.mn/site/news_full/7022)

<sup>65</sup> Монгол Улсын шүүхийн тайлан (2018 он). [http://www.judcouncil.mn/site/news\\_full/8704](http://www.judcouncil.mn/site/news_full/8704)

<sup>66</sup> Монгол Улсын шүүхийн тайлан (2019 он). [http://www.judcouncil.mn/site/news\\_full/10084](http://www.judcouncil.mn/site/news_full/10084)

<sup>67</sup> Монгол Улсын шүүхийн тайлан (2020 он). [https://www.judcouncil.mn/site/news\\_full/11129](https://www.judcouncil.mn/site/news_full/11129)

ийн 11.7 дугаар зүйлд заасан “байнга” гэх шинжээс шалтгаалан гэмт хэрэг болж чадахгүй байсныг харуулж байна.<sup>68</sup>

Мөн 2018, 2019, 2020 оны шүүн таслах ажиллагааны тайлангаас харахад эхнэр, хамтран амьдрагч эмэгтэй бие махбодын хүчирхийлэлд байнга өртөж байгаа нь тодорхой байна.

### *Хүснэгт 5. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн*

Д/д	Утга	2018 он	2019 он	2020 он
1	Нийт хүн	1136	1193	1552
2	Үүнээс эмэгтэй	969	1022	1255
3	Хүчирхийллийн хэлбэр (бие махбод)	1053	1101	1465
4	Үргэлжилсэн хугацаа (1 жил хүртэл)	951	1084	1157
5	Гэр бүлийн хамаарал (эхнэр)	607	374	511
	Гэр бүлийн хамаарал (хамтран амьдрагч)	230	442	644

Дээрх хүснэгтийн мэдээлэл нь гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, бие биедээ үнэнч, итгэлтэй байх, халамжлах, хүндэтгэх зэрэг үнэт зүйлс алдагдсаар байгааг илтгэнэ.

Мөн ЭХТА-ийн 11.7 дугаар зүйл болон бусад гэмт хэрэг (ЭХТА-ийн 10.1.2.8, 10.4.1, 11.1.2.1, 11.4.2.1, 11.6.2, 12.1.2.3) харилцан уялдаагүй байна. Тухайлбал, гурав болон түүнээс дээш удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол гэмт хэргийн энгийн бүрэлдэхүүнд тооцсон атлаа эсрэгээр эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр, хөнгөн гэмтэл учруулах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж болгосон нь хууль хоорондын зөрчил, алдаа юм.<sup>69</sup>

Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтаас үзвэл ЭХТА-ийн бусад гэмт хэрэгт заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн диспозици нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр

<sup>68</sup> Нээлттэй Нийгэм Форум, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал, УБ., 2021, 20 дахь тал.

<sup>69</sup> <http://gan-baatar.blogspot.com/2017/08/blog-post.html>

бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн диспозицоос өөр буюу тодорхой давтамж заагаагүй, нэг удаагийн тохиолдол хамаарахаар байна. Тухайлбал:

- УДШ-ийн 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 19 дүгээр тогтоолд<sup>70</sup> “Шүүгдэгч Б.Ж нь 2020 оны 2 дугаар сарын 12-ны орой согтуугаар Сэлэнгэ аймгийн Ерөө сумын эрүүл мэндийн төвийн байранд албан үүргээ гүйцэтгэж байсан хамтран амьдрагч Я.Б-гийн цээжинд хутгалан, улмаар уг үйлдлийг нь гэрч Б.А таслан зогсоосны дараа гадагшаа гарч эмнэлгийн хашаан дотор явж байсан хохирогч У.Э-гийн хэвллийд хутгалж, тэдгээрийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулсан үйл баримтыг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтуудад тулгуурлан хоёр шатны шүүх эргэлзээгүй, хөдөлбөргүй нотлон тогтоосон байна. Хохирогч Я.Б, У.Э, гэрч Б.А нарын хэлж мэдүүлснээр тухайн үед болж өнгөрсөн үйл явдлыг ийнхүү сэргээн тогтоосон байх бөгөөд уг нөхцөл байдалд үндэслэн хоёр шатны шүүх шүүгдэгчийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хоёр хүнийг санаатай алахыг завдсан гэж үзэж, түүний гэмт үйлдлийн талаар хэргийн бодит байдалд нийцсэн хууль зүйн дүгнэлт хийжээ” гэж ЭХТА-ийн 10.1 дүгээр зүйлийн 2.8 (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж) дахь заалтыг;
- УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 552 дугаар тогтоолд<sup>71</sup> “Шүүгдэгч Б.Т нь 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдөр Баянгол дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 12-127 тоотод оршин суух гэртээ 4 настай эрэгтэй О.Э-г биеэ хамгаалж чадахгүй бага насны хүүхэд болохыг мэдсээр байж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн бие махбодын, сэтгэл санааны шаналал, зовуурь үүсгэн зодож эрүүл мэндэд нь хүнд хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн нь шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар тогтоогдсон талаарх анхан болон

<sup>70</sup> <http://new.shuukh.mn/eruuhyanalt/2735/view>

<sup>71</sup> <http://new.shuukh.mn/eruuhyanalt/1928/view>

давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий болжээ” гэж ЭХТА-ийн 11.1 дүгээр зүйлийн 2.1 (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж) дэх заалтыг;

- Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 905 дугаар магадлалд<sup>72</sup> “Шүүгдэгч Д.Д нь 2019 оны 12 дугаар сарын 5-наас 6-нд шилжих шөнө Баянгол дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Прогресс” нэртэй зочид буудлын 407 тоот өрөөнд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хамтран амьдрагч А.М-ийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлэн хүчиндэж, мөн уг гэмт хэргийг үйлдэх явцдаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хамтран амьдрагч А.М-ийг гараараа цохиж, хөлөөрөө өвдөглөж эрүүл мэндэд нь баруун 3, 4 дүгээр хавирганы зөрүүтэй хугарал, нүүр цээжний зөөлөн эдийн няцрал, дээд уруулд шарх, нүүр, хүзүү, дээд, доод мөчид хэвллийгээр олон тооны цус хуралт, зулгаралт гэмтэл бүхий хүндэвтэр хохирол санаатай учруулсан гэмт хэрэг тус тус үйлдсэн болох нь тогтоогдсон тул анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол үндэслэлтэй байна” гэж ЭХТА-ийн 11.4 дүгээр зүйлийн 2.1 (гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж) дэх заалт, ЭХТА-ийн 12.1 дүгээр зүйлийн 2.3 (гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж) дахь заалтыг;
- Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 556 дугаар магадлалд<sup>73</sup> “Шүүгдэгч Э.Г нь 2017 оны 11 дүгээр сарын 29-нөөс 30-нд шилжих шөнө Баянгол дүүргийн 22 дугаар хороо, Зүүннарангийн 13-210 тоот гэртээ гэр бүлийн хамаарал бүхий эхнэр М.Э-г гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, эрүүл мэндэд нь хөнгөн хохирол учруулсан, мөн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, хүчээр бэлгийн харилцаанд орсон гэмт хэрэг үйлдсэн болох нь хэрэгт

<sup>72</sup> <http://new.shuukh.mn/eruuudavah/10219/view>

<sup>73</sup> <http://new.shuukh.mn/eruuudavah/5699/view>

цугларсан нотлох баримтуудаар нотлогдон тогтоогджээ” гэж ЭХТА-ийн 12.1 дүгээр зүйлийн 2.3 (гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүчиндэж) дахь заалтыг тус тус тайлбарлан хэргийн зүйлчлэлийг хийсэн байна.

Дээрх шүүхийн шийдвэрүүдэд нэг удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдэн хохирогчийн амь насыг хөнөөсөн, хүнд, хүндэвтэр гэмтлийн зэрэг тогтоогдсон, хүчиндсэн бол шууд тухайн гэмт хэргийн хүндруүлэх бүрэлдэхүүн болгон зүйлчилж, эрүүгийн хариуцлага оногдуулжээ. Гэтэл ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл нь “байнга” гэсэн шинжээсээ хамаарч олон удаагийн гэмт үйлдэл байхаар байна. Энэ нь Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг алдагдуулсан зохицуулалт болсон бөгөөд тус хуульд хоёр өөр төрлийн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх диспозици зэрэгцэн байгааг харуулж байна.

### **2.2.3. Адил төстэй зөрчлийн асуудал**

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчилтэй ойролцоо, давхар илрэх үйлдлүүдийг Зөрчлийн тухай хуулиар зохицуулсан. Үүнд:

- 1) ЗтХ-ийн 5.2 дугаар зүйл буюу Танхайрах: Олон нийтийн газарт эсхүл орон байранд хэрүүл маргаан үүсгэх, бусдыг өдөөн хатгах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах, олон нийтийг үл хүндэтгэх, үйлчилгээний болон дарааллын журам зөрчих зэргээр биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл хамаардаг. Үүнээс орон сууцанд хэрүүл маргаан үүсгэх, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулах нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэрэгтэй төстэй, хамааралтай байдал. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явцад гэр бүлийн гишүүдийн хооронд үл ойлголцол гарч хэрүүл маргаан үүсдэг, мөн дуу чимээ, доргилт гарч оршин суугчдын амгалан тайван байдал алдагддаг. Тиймээс хүчирхийлэл үйлдэгч этгээдийн танхайрах үйлдлийг гэр бүлийн хүчирхийлэл

үйлдэх зөрчил, гэмт хэргээс хэрхэн ялган зааглах, давхар зүйлчлэх эсэх зэрэг асуудал үүсэж байна. Энэ нь мөрдөгч, прокурорын мөрдөн шалгах ур чадвараас ихээхэн хамаарах болно.

- 2) ЗтХ-ийн 5.5 дугаар зүйл буюу Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах: Үүнд нийтийн зориулалттай орон сууцанд шөнийн цагаар бусад оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах үйлдэл хамаардаг. Ихэвчлэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч этгээд архидан согтуурсан үедээ шөнийн цагаар оршин суугчдын унтаж амрах, чимээгүй орчинд байх, өөрийнхөө орон зайд чөлөөтэй байх халдашгүй эрхийг зөрчиж, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг. Бусад гэдэгт гэр бүлийн гишүүд бас багтах боломжтой тул зөрчил, гэмт хэргийн зүйлчлэлийг зөв хийх шаардлагатай.
- 3) ЗтХ-ийн 6.20 дугаар зүйл буюу Хүүхдийн эрхийг зөрчих: Үүнд хүүхдийн бие махбодод халдах, үл хайхрах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэх үйлдлүүд хамаардаг. Хүүхэд гэдэгт 18 насанд хүрээгүй, бие махбод болоод сэтгэл зүйн хувьд бүрэн төлөвшөөгүй хүнийг ойлгох бөгөөд ихэвчлэн гэр бүлийн гишүүдтэйгээ хамт байдаг. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэлд өртөх өндөр магадлалтай. Гэтэл ЗтХ-ийн 6.20 дугаар зүйлд заасан хүүхдийн эрхийг зөрчих зөрчил нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид мөн хамаархаар байна. Тухайлбал, хүүхдээ бие махбодод нь гэмтэл учруулахгүйгээр зодсон үйлдлийг хэрхэн зүйлчлэх нь эргэлзээтэй.

#### **2.2.4. Хөөн хэлэлцэх хугацааны асуудал**

Гэмт хэрэг үйлдсэнээс хойш уг этгээдийг илрүүлж, улмаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хугацаа өнгөрсөн, тэр хугацаанд

гэмт хэрэг шинээр үйлдээгүй бол тухайн этгээд нийгэмд аюулгүй, эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагагүй болсон нөхцөл байдлыг хөөн хэлэлцэх хугацаа гэдэг. 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд хөөн хэлэлцэх хугацааг зорчих эрхийг хязгаарлах болон хорих ялын хэмжээнээс хамааран дараах байдлаар хуульчилсан.

#### *Хүснэгт 6. Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаа*

д/д	Ял	Хөөн хэлэлцэх хугацаа	Гэмт хэргийн ангилал
1	Хорих ял: 1 жил хүртэл Зорчих эрхийг хязгаарлах ял: 1 жил, түүнээс доош	1 жил	Хөнгөн
2	Хорих ял: 6 сараас 3 жил хүртэл Зорчих эрхийг хязгаарлах ял: 6 сараас 3 жил хүртэл	3 жил	Хөнгөн
3	Хорих ял: 1-ээс 8 жил хүртэл Зорчих эрхийг хязгаарлах ял: 1 жилээс дээш	5 жил	Хөнгөн, хүнд
4	Хорих ял: 5-аас 15 жил хүртэл	12 жил	Хүнд
5	Хорих ял: 12-оос 25 жил хүртэл, бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй	20 жил	Хүнд
6	Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг	5 жил	Хөнгөн
7	Бүх насаар хорих ял оногдуулахаар заасан гэмт хэрэг, хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэг	Байхгүй	Хүнд

Гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэнээс хойш дээрх хугацаа өнгөрсөн нь тогтоогдвол эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татах болдоггүй. Хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолдог. Харин хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байхад дахин гэмт хэрэг санаатай үйлдвэл сүүлчийн гэмт хэрэг үйлдсэн үеэс гэмт хэрэг тус бүрд шинээр эхлэн тоолдог.

Гэтэл ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааг баримтлахгүй байна. Тухайлбал:

- Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 1891 дүгээр цагаатгах тогтоолд<sup>74</sup> “Шүүгдэгч Г.Г нь согтуурсан үедээ 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр, 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр болон 2019 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн болох өөрийн эхнэр Ж.А-г үснээс нь зулгааж, өшиглөж зодсон үйл баримтыг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэхэд гэмт хэргийн шинжийг агуулсан үйлдэл тогтоогдохгүй байна. Учир нь шүүгдэгч Г.Г нь 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр болон 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн үйлдэлдээ Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас Зөрчлийн тухай хуулийн дагуу шүүхийн шийтгэвэр оногдуулсан байна. Шүүгдэгчид хамгийн сүүлд оногдуулсан шийтгэлээс хойш 11 сарын хугацаа өнгөрсөн байх ба Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлд зааснаар тус хуулийн тусгай ангид баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэнээс хойш 6 сарын хугацаа өнгөрч хөөн хэлэлцэх хугацаа дууссан байна. Ийнхүү зөрчлийн хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа дууссанаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан байнга гэх шинж үгүйсгэгдэж байна. Тиймээс ЭХХШтХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д заасны дагуу гэмт хэргийн шинжгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Г.Г-г цагаатгасугай” гэсэн байна.

Тус анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолд прокурор эсэргүүцэл бичсэн боловч Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 184

<sup>74</sup> <http://new.shuukh.mn/eruanhan/39410/view>

дүгээр магадлалаар<sup>75</sup> анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, прокурорын эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгожээ.

Улмаар анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрт прокурор эсэргүүцэл бичсэн боловч УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 202 дугаар тогтоолоор<sup>76</sup>

- “Хэргийн үйл баримтаас үзэхэд шүүгдэгч Г.Г нь 2018 оны 05 дугаар сарын 09-ний өдөр, 2018 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр болон 2019 оны 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд эхнэр Ж.А-г зодсон үйлдэл тогтоогдсон бөгөөд тооны хувьд байнга гэсэн шинжийг хангасан байна. Хууль тогтоогч ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлүүдийн сэдэлт, зорилгыг тодорхойлсон боловч уг үйлдлүүдийн хоорондох хугацааны хамаарлыг нарийвчлан тодорхойлоогүйгээс энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн маргаан үүссэн байх тул энэхүү эргэлзээ, маргааныг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтай байх зарчмыг баримтлан дараах тайлбар, хууль хэрэглээний жишиг тогтоох үндэслэлтэй гэж үзэв. Энэхүү гэмт хэргийн шинжийг бүрдүүлдэг “байнга” гэх ойлголт нь тооны давтамжаас хууль зүйн ойлголт руу шилжихдээ хууль зүйн алдаагүй байх ёстой бөгөөд гэмт хэргийн шинжийг хангаж буй гурав ба түүнээс дээш удаагийн үйлдлийн хооронд зөрчилд хариуцлага хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх шаардлага нь тухайн 3 үйлдлийг нэгтгэн дүгнэх хууль зүйн үндэслэл болно. Зөрчлийн тухай хуулийн хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх үндэслэл нь 3, түүнээс дээш удаагийн гэр бүлийн хүчирхийллийн үйлдэл болон зөрчлүүдийн 1 нь дангаараа гэмт хэргийн шинжийг хангахгүй тул Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ашиглах боломжгүй, харин үйлдэл болон зөрчлүүдийн нийлбэр Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэрэгт шилжиж байгаагаас үүдэлтэй юм. Тиймээс

<sup>75</sup> <http://new.shuukh.mn/eruudavah/9147/view>

<sup>76</sup> <http://new.shuukh.mn/eruuhyanalt/2270/view>

анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрүүдийг хэвээр үлдээж, прокурорын эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгосугай” гэж дүгнэжээ.

Ийнхүү УДШ-ийн дээрх тогтоол гарснаас хойш эрүүгийн хэргийн анхан, давах, хяналтын шатны шүүхүүд “байнга” гэх шинжид заасан гурав болон түүнээс дээш үйлдлийн хоорондох хугацааг Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацааны дагуу зургаан сараар тооцож шийдвэрлэсээр байна. Жишээлбэл, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 820 дугаар цагаатгах тогтоол<sup>77</sup>, Өмнөговь аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 35 дугаар цагаатгах тогтоолыг<sup>78</sup> тус тус дурдаж болох юм.

Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно”, 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” гэж хууль ёсны зарчмын агуулгыг тодорхойлсон. Тодруулбал, гэмт хэрэг, ялын тухай асуудал Эрүүгийн хуулиас өөр салбар хуулиар зохицуулагдах ёсгүй гэсэн үг юм.<sup>79</sup> Түүнчлэн эрүүгийн хариуцлагын аль нэг асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн нийтлэг үндэслэл, ерөнхий болон тусгай ангийн зүйл, заалтуудыг нарийн чанд баримтлах, гагцхүү хуульд захирагдах нөхцөлийг бүрдүүлж байна.<sup>80</sup> Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулиас өөр хуулиар гэмт хэрэг мөн эсэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэхгүй бөгөөд нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хэлмэгдүүлэхгүй байх, нөгөө талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завшуулахгүй байх асуудал юм. Гэтэл шүүх ЭХТА-ийн 11.7

<sup>77</sup> [https://shuukh.mn/single\\_case/57985?daterange=2021-07-01%20-%202021-11-12&id=1&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/57985?daterange=2021-07-01%20-%202021-11-12&id=1&court_cat=2&bb=1)

<sup>78</sup> [https://shuukh.mn/single\\_case/54153?daterange=2017-07-01%20-%202021-07-01&id=1&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/54153?daterange=2017-07-01%20-%202021-07-01&id=1&court_cat=2&bb=1)

<sup>79</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 41 дэх тал.

<sup>80</sup> Г.Совд, Монгол Улсын эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2002, 11 дэх тал.

дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг мөн эсэхийг ЗоТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хөөн хэлэлцэх хугацаагаар тодорхойлж байна. Ийнхүү шийдвэрлэж буй нь ЭХХШТХ-ийн 1.15 дугаар зүйлд заасан Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ гэсэн гэм буруугүйд тооцох зарчимтай нийцэхгүй юм. Учир нь “байнга” гэсэн шинжийг тайлбарлахын тулд ЭХ болон ЭХХШТХ-ийн үндсэн зарчмуудыг хооронд нь зөрчилдүүлэх бус, эдгээр зарчимд нийцүүлэх шаардлагатай.

## 2.2.5. Эрүүгийн хариуцлагын асуудал

Эрүүгийн хариуцлага нь гэмт хэргийн бүрэлдэхүүний бүх шинжийг агуулсан үйлдэл, эс үйлдэхүй хийсэн, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх зүйн байдалд хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын онцгой арга хэмжээ юм. Өргөн утгаараа а) гэмт хэрэг үйлдэгдсэн фактаас шууд үүдэлтэй, эрүүгийн хуулийн хэм хэмжээнд үндэслэгдсэн гэмт хэргийн субъект болох этгээдийн хийсэн хэргийнхээ төлөө төр, түүнийг төлөөлсөн байгууллагын өмнө хүлээх хариуцлага; б) үйлдэгдсэн гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдэд төрийн нэрийн өмнөөс шүүхийн тогтоолоор өгч буй сөрөг үнэлгээ; в) гэм буруутай нь шүүхээр нотлогдсон шүүгдэгчид оногдуулах Эрүүгийн хуульд заасан төрийн албадлагын арга хэмжээ гэсэн үндсэн шинжийг агуулж байдаг гэмт хэрэг үйлдэгдсэн хууль зүйн фактын нийгэм, эрх зүйн үр дагавар юм. Явцуу утгаараа гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай этгээдэд эрүүгийн хуулийн хэм хэмжээг хэрэглэсний үр дүн, эрх зүйн үр дагавар гэж тодорхойлж болно.<sup>81</sup>

Эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг зөвхөн Эрүүгийн хуулиар тогтоох бөгөөд ял, албадлагын арга хэмжээ гэсэн хоёр үндсэн хэлбэртэй. 2015 оны Эрүүгийн хуулиар торгох, нийтэд

<sup>81</sup> Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2010, 145 дахь тал.

тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих гэсэн дөрвөн үндсэн ял, эрх хасах гэсэн нэг нэмэгдэл ялын төрөлтэй байхаар заасан. Харин үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах, эмнэлгийн чанартай хөрөнгө, орлогыг хураах гэсэн албадлагын гурван төрлийн арга хэмжээ авдаг.

*Эрүүгийн хариуцлагын зорилго нь:*

- А. Гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх: Хэн нэгэн гэмт хэрэг үйлдэх явцад түүний улмаас өөр хэн нэгний эрх, ашиг сонирхолд аюул учирч байдаг. Тиймээс эрүүгийн хариуцлага нь тэрхүү зөрчигдсөн эрхийг аль болох өмнөх байдалд буцаан авчрахыг зорьдог.
- Б. Хохирлыг нөхөн төлүүлэх: Гэмт хэрэг үйлдэгдсэний улмаас учирсан хохирол, хор уршгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх нь чухал. Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд учруулсан хохирлоо сайн дураараа нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан бол эрүүгийн хариуцлагаас хөнгөрүүлэх, чөлөөлөх нөхцөл үүсдэг.
- В. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх: Гэмт хэрэг үйлдэж, гэм буруутай нь тогтоогдсон бол ялын бодлогоор дамжуулан тухайн этгээдийн эрх, эрх чөлөөнд ямар нэг байдлаар хязгаарлалт тогтоодог. Тиймээс үйлдсэн гэмт хэргийн хариуцлагын үр дагаврыг амсах нь шударга ёсонд нийцнэ.
- Г. Гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшиүүлэх: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийн тодорхой эрхийг хязгаарлаж, үйлдсэн хууль бус үйлдлийн үр дагаврыг нь ухамсарлуулан ойлгуулах, гэмшүүлэх, нийгэмд биеэ зөв авч явах, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг болгох нь чухал юм.
- Д. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх: Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хурдан шуурхай илрүүлж, түүнд тохирсон хариуцлага хүлээлгэх ёстой. Ингэснээр хууль бус үйлдэл хийвэл хариуцлага хүлээнэ гэдэг итгэл үнэмшил, болгоомжлолыг буруутай этгээд ойлгож авна. Мөн гэмт хэрэг үйлдэх гэж буй бусад этгээдэд хандсан сануулга болдог.

Гэтэл 2015 оны Эрүүгийн хуульд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт оногдуулах эрүүгийн хариуцлага нь оновчтой зохицуулалт болсон эсэх, шүүхээс оногдуулж буй ялын бодлого гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, түүнийг бууруулахад нөлөө үзүүлж чадаж байна уу гэдэг асуулт урган гарч байна. Энэхүү судалгааны хүрээнд эрүүгийн хариуцлагын зорилго хэрхэн биелж байгааг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх байдлаар тодруулъя.

**Асуудал 1.** ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон ЗтХ-ийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал

#### *Хүснэгт 7. Эрүүгийн болон зөрчлийн хариуцлагын харьцуулалт*

ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	ЗтХ-ийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг
Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон; харгис хэрцгий харилцсан, догшин авирласан, тарчлаасан; хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан.	Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон; хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан; бусадтай харилцахыг хязгаарласан; хуваарьт болон дундын хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан.

Хариуцлага	
6 сараас 1 жил хүртэл зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хорих ял	7-гоос 30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл
Албадлагын арга хэмжээ	Албадлагын арга хэмжээ

ЗтХ-ийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн бол долоогоос 30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулж байна. Харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрээр оногдуулсан

эрүүгийн хариуцлагад дүн шинжилгээ хийсэн үр дүнг Хүснэгт 8-д харуулав.

*Хүснэгт 8. ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт анхан шатны шүүхээс эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал*

д/д	Огноо	Зүйл, хэсэг	Хариуцлагын хэмжээ			Нийт
			ЭХТА	Чөлөөлөх	Тэнсэх	
1		11.7.1.1			6 сар – 5 жил	6 сар – 1 жил
2		11.7.1.2			6 сар – 2 жил	6 сар – 1 жил
3		11.7.1.3			1 жил	
д/д	2017.07.01 2021.07.01	Зүйл, хэсэг	Шийдвэрийн тоо			
1		11.7.1.1	1	29	26	56
2		11.7.1.2		20	12	32
3		11.7.1.3		1		1
		Нийт	1	50 /56%/	38 /43%/	89

Түүврийн аргаар сонгон авсан анхан шатны шүүхийн 89 шийдвэрт оногдуулсан эрүүгийн хариуцлагад дүн шинжилгээ хийхэд 38 шийдвэр буюу 43 хувьд нь 6 сараас 1 жилийн хооронд хорих ял оногдуулжээ. Харин 51 шийдвэр буюу 57 хувьд зургаан сараас таван жилийн хооронд тэнсэх болон ялаас чөлөөлсөн байна.

*Асуудал 2. ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал*

**Хүснэгт 9. ЭХТА-ийн 11.6 дугаар зүйл болон 11.4 дүгээр зүйлийн  
эрүүгийн хариуцлагын харьцуулалт**

ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг	ЭХТА-ийн 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг
Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хөнгөн хохирол санаатай учруулах	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүндэвтэр хохирол санаатай учруулах
Энэ гэмт хэргийг энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтай үйлдсэн	Энэ гэмт хэргийг энэ хуулийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар үйлдсэн
<b>Хариуцлага</b>	
450 нэгжээс 2,700 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэлх хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх эсхүл 1 сараас 6 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял	2,700 нэгжээс 14,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах эсхүл 6 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ял
Албадлагын арга хэмжээ	Албадлагын арга хэмжээ

2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 11.4 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хөнгөн, хүндэвтэр хохирол учруулсан хэргийг хянан шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрээр оногдуулсан эрүүгийн хариуцлагад дүн шинжилгээ хийсэн үр дүнг Хүснэгт 10-т харуулав.

**Хүснэгт 10. ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон 11.4 дүүрэг зүйлийн 2 дахь хэсэгт анхан шалтны шийхээс зөвхөн хариуцлагага оногдуулсан байдал**

№/№	Огноо	Зүйл, хэсэг			Хариуцлагын хэмжээ			Нийт
		ЭХТА	Чөлөөлөх	Тэнсэх	Toprox	Нийтэд	тусгай ажил	
1	2021.07.01	11.6.2			450,000 – 2,700,000	240 – 600 цаг		
2	2017.07.01	11.4.2.1		8 сар – 3 жил	2,700,000 – 5,400,000		6 сар – 2 жил 6 сар	
3	2017.07.01	11.4.2.3		1 жили – 2 жил			7 сар	
		Зүйл, хэсэг			Шийдвэрийн тоо			
1	11.6.2				58	12		70
2	11.4.2.1	2		55	13		17	87
3	11.4.2.3		2			1	3	3
<b>Нийт</b>	<b>2 (1%)</b>	<b>57 (36%)</b>		<b>71 (44%)</b>	<b>12 (8%)</b>	<b>18 (11%)</b>	<b>160</b>	

Түүврийн аргаар сонгон авсан анхан шатны шүүхийн 160 шийдвэрт оногдуулсан эрүүгийн хариуцлагад дүн шинжилгээ хийхэд 57 шийдвэр буюу 36 хувьд 6 сараас 3 жилийн хооронд тэнссэн байна. Харин 71 шийдвэр буюу 44 хувьд 450,000 төгрөгөөс 5,400,000 төгрөгийн хооронд торгох ял оногдуулжээ.

Үүнээс ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хөнгөн хохирол учруулсан 58 гэмт хэрэг буюу 82 хувьд торгох ял оногдуулсан нь сонирхол татлаа. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолоос яагаад торгох ял оногдуулсныг мэдэх боломжгүй юм. Харин Ховд аймгийн шүүгчдээс авсан санал асуулгад “ихэнх хэргийн хохирогч, шүүтгэгч нар шүүхэд хэрэг ирэх хугацаанд хоорондоо эвлэрч, тохиролцож, мөнгөн торгууль төлж уг асуудлыг дуусгахыг хүсдэг тул энэ зүйл заалтыг хуулийн хүрээнд хэрэглэдэг” гэж дурдсан байна.<sup>82</sup> Хэрэв анхан шатны шүүх энэ хандлагаар ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт торгох ял оногдуулах юм бол тухайн гэр бүлийн гишүүдэд эдийн засгийн хүчирхийлэл үүсэх өндөр магадлалтай. Учир нь торгуулийн төлбөрийг тухайн гэр бүлийн гишүүд хамтран төлөх эсхүүл гэр бүлийн орлого буурах, тэжээн тэтгэх үүргээс зайлсхийх зэргээр эдийн засгийн хараат байдалд орох болно.

Мөн ЭХТА-ийн 11.4 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж хүндэвтэр хохирол учруулсан 55 гэмт хэрэг буюу 63 хувьд тэнсжээ. Хөнгөн хохирол учруулсан шүүгдэгч ихэвчлэн торгох ялаар шийтгүүлж байхад хүндэвтэр буюу илүү хүнд хохирол учруулсан шүүгдэгчид ял оногдуулахгүйгээр тэнсэж байгаа нь шүүхээс оногдуулж буй ялын бодлого оновчтой эсэхэд дахин эргэлзээ төрүүлж байна. Угтаа бол шүүхэд ямар төрлийн ял оногдуулах, тэрхүү ялыг хэр хэмжээтэй байлгах бүрэн эрх нь бий. Гэтэл тэрхүү боломжийг эрүүгийн хариуцлагын зорилгод нийцүүлэхгүй байна.

<sup>82</sup> Ж.Саруул, Л.Оюунцэцэг, Ж.Цэцэгмаа нар, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэргийн шийдвэрлэлт, ял шийтгэл оногдуулж буй байдал орон нутагт, Бодлогын судалгааны тайлан, УБ., 2021, 60-61 дэх тал.

Түүнчлэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн зөрчлийн хэрэгт баривчлах шийтгэл оногдуулсан хэр нь гэмт хэрэгт тэнсэх арга хэмжээ авч байгаа нь шүүхээс оногдуулж буй ялын бодлого эрүүгийн хариуцлагын зорилгод нийцэж байгаа эсэхэд эргэлзээ үүсгэж байна. Учир нь баривчлах шийтгэл нь зөрчил үйлдсэн, гэм буруутай этгээдийг олон нийтээс тусгаарлан тодорхой дэглэм бухий байранд saatuulj, зорчих, дураараа явах, бусадтай чөлөөтэй харилцах зэрэг тодорхой эрхийг хязгаарладаг бол тэнсэх арга хэмжээ нь тодорхой хугацаа тогтоож, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх талаар хянан харгалздаг. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт оногдуулах хариуцлага зөрчилд оногдуулах хариуцлагаас илүү хөнгөн, хялбар байгаа нь ялын бодлого оновчтой биш байгааг илтгэнэ.

#### **2.2.6. Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ**

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэсэн Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоолыг<sup>83</sup> судлан, тэдгээрт үндэслэн дүн шинжилгээ хийхийг зорилоо.

2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасныг үндэслэн шийдвэрлэсэн УДШ-ийн 13 тогтоол байх<sup>84</sup> бөгөөд хууль зүйн үндэслэлийг тайлбарлан шийдвэрлэсэн шүүхийн дараах дөрвөн шийдвэр байна.

<sup>83</sup> Цаашид “УДШ-ийн тогтоол” гэх.

<sup>84</sup> <http://new.shuukh.mn> вэбсайтаас хайлт хийсэн бөгөөд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн хариу албан бичигт заасан тоотой адил байв.

**Хүснэгт 11. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэсэн УДШ-ийн тогтоол**

Д/д	Огноо	Дугаар	Илтгэгч шүүгч	Зүйл, хэсэг (ЭХТА)
1	2019.10.30	572	Д.Ганзориг	11.7.1.2
2	2019.12.04	630	Ч.Хосбаяр	11.6.2, 11.7.1.1
3	2020.04.27	203	Д.Ганзориг	11.7.1.1
4	2020.06.22	342	Б.Батцэрэн	11.7.1.1

- 1) УДШ-ийн 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн  
572 дугаар тогтоол

Монгол Улсын иргэн, 1972 онд төрсөн, эрэгтэй, ял шийтгүүлж байгаагүй, М овогт Л.Э нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнтэй байнга харгис хэрцгий харилцаж, догшин авирлаж гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэрэгт холбогджээ.

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Л.Э-г “гэр бүлийн харилцаатай хүнтэй байнга догшин авирласан” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т зааснаар зургаан сарын хугацаатай хорих ялаар шийтгэсэн. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гаргасан гомдлуудыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Харин хяналтын шатны шүүх дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Анхан болон давж заалдах шатны шүүхээс Л.Э нь 2018 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 1362 дугаар шийтгэврээр эхнэр В.О-д агсам тавьж, хэл амаар доромжилж, хүсэл зоригийн нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, 2018 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 1473 дугаар шийтгэврээр эхнэр В.О-д агсам тавьж, хэл амаар доромжилж, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 37 дугаар шийтгэврээр эхнэр В.О руу аяга шидэж, нуруу руу нь цохиж, гэр бүлийн хамаарал бүхий

харилцаатай хүнийг зодсон зөрчилдөө тус тус Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн тохирох хэсгүүдээр буюу гурван өөр үндэслэлээр албадан сургалтад хамрагдах, баривчлах шийтгэл тус тус хүлээж байсан нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан гэмт хэргийн шинжийг хангасан гэж дүгнэн гэм буруутайд тооцож, хорих ял оногдуулж шийдвэрлэжээ.

Хэргийн үйл баримтаас үзэхэд шүүгдэгч Л.Э нь дээрх үйлдэлдээ Зөрчлийн тухай хуулийн дагуу дөрвөн удаа, гурван өөр үндэслэлээр шийтгэл хүлээсэн нөхцөл байдалд Эрүүгийн хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна. Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих” зөрчлийн бүрэлдэхүүний объектив талын үндсэн шинж нь “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн”-ийг зодсон, хүсэлт зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан шинжийн аль нэг нь эсхүл хэд хэд нь тогтоогдож байгаа тохиолдолд хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан. Гэтэл ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн объектив талын үндсэн шинж нь “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүн”-ийг байнга зодсон, харгис хэрцгий харилцсан, догшин авирласан, тарчлаасан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэх гурван шинжийн аль нэгийг эсхүл хэд хэдэн шинжийг тус бүр байнга үйлдсэн байхыг шаардсан байх бөгөөд Л.Э-гийн шийтгүүлсэн зөрчлөөс В.О-г зодсон, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан гэх хоёр зөрчлөөс бусад нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжид хамаarahгүй байна.

ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний байнга гэсэн шинжийг хангахад дээрх хоёр хуулийн ижил шинжүүдээс давтагдаж буйгаар нь дүгнэлт хийх хүрээгээ тогтоож байх нь зөрчил ямар тохиолдолд гэмт хэрэгт шилжиж байгааг тодорхойлох хууль зүйн үндэслэл болно. Нэгтгэн

дүгнэвэл Л.Э-гийн дөрвөн удаа Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шийтгүүлсэн нөхцөл байдал нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2-т заасан гэмт хэргийн шинжийг хангахгүй байх тул анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ. Иймд шүүгдэгчийн өмгөөлөгчийн гомдлыг хүлээн авч анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, шүүгдэгч Л.Э-д холбогдох хэргийг “гэмт хэргийн шинжгүй” гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэжээ.

### Дүн шинжилгээ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж буй хүний үйлдлийг гэмт хэргээсхүл зөрчил гэж үзэхэд гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Дээрх шийдвэрээс үзэхэд хэргийн зүйлчлэл буюу гэмт хэргэг, зөрчлийн бүрэлдэхүүний шинжийг УДШ ялан тайлбарласан байна. Тодруулбал, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчлийн бүрэлдэхүүний шинжээс “байнга” гэсэн шинжээр ялгагдаж байх бөгөөд шүүгдэгч Л.Э нь хууль бус үйлдэлдээ Зөрчлийн тухай хуулийн дагуу өөр өөр үндэслэлээр дөрвөн удаа шийтгүүлсэн нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжээс “байнга” гэсэн шинжээр ялгагдаж байх бөгөөд шүүгдэгч Л.Э нь хууль бус үйлдэлдээ Зөрчлийн тухай хуулийн дагуу өөр өөр үндэслэлээр дөрвөн удаа шийтгүүлсэн нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан байнга гэсэн шинж нь тухайн гэмт хэргийн диспозици бурд гурав болон түүнээс дээш байхаар тайлбарласан байна.

- 2) УДШ-ийн 2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 630 дугаар тогтоол

Монгол Улсын иргэн, 1992 онд төрсөн, эрэгтэй, ял шийтгүүлж байгаагүй, О овогт Э.Т нь ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулах”, ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1

дэх хэсгийн 1.1-т заасан “Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодох” гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Э.Т-г “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан”, “гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг байнга зодсон” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож ЭХХШтХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1.2-т зааснаар ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан хэргүүдийг хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгож, түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж шийдвэрлэсэн байна. Харин шүүгдэгч, түүний өмгөөлөгч гэм буруутайд тооцсон тус шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч хэргийг хэрэгсэхгүй болгох буюу цагаатгах үндэслэлээр давж заалдах гомдол гаргасан боловч Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолыг хэвээр үлдээн шүүгдэгч, түүний өмгөөлөгчийн гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.

Харин хяналтын шатны шүүх дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Шүүгдэгч Э.Т-г Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, “Роял грийн вилла” хотхоны ... дугаар байрны ... тоотод гэр бүлийн хамаарал бүхий этгээд болох хамтран амьдрагч Б.Д-г 2017 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр гэрт баяр наадам хийсэн шалтгаанаар, мөн 2018 оны 3 дугаар сарын 22-ны өдөр даварлаа гэх үндэслэлээр маргалдаж тус тус зодсон, 2018 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр хов зөөсөн гэх шалтгааны улмаас маргалдаж, улмаар түүнийг зодож биед нь хөнгөн гэмтэл учруулсан үйл баримтыг анхан болон давж заалдах шатны шүүх зөв тогтоосон боловч Э.Т-гийн эдгээр үйлдэл нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй байсан гэж хэргийн бодит байдлаас зөрүүтэй эрх зүйн дүгнэлт хийжээ.

ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1-д заасан бие махбодын, сэтгэл санааны, эдийн застгийн, бэлгийн зэрэг хүчирхийллийн аль нэгийг байнгын шинжтэй үйлдсэн тохиолдолд дээрх гэмт хэргээр

зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бүрдэнэ. Шүүгдэгч Э.Т, хохирогч Б.Д нарын хооронд үүссэн маргаан, тэмцэл нь нэг тал давамгайлсан гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлаас нийгмийн шалтгаант шинж байдлаар ялгаатай байж эхнэр, нөхрийн хоорондын таарамжгүй харилцаанаас улбаатай ахуйн суурьтай гарсан байх тул шүүгдэгч Э.Т-г гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн гэж үзэх, бусдын эрүүл мэндэд хөнгөн гэмтэл учруулах гэмт хэргийг энэ шинжээр үйлдсэн гэж хүндрүүлэн үзэх хууль зүйн үндэслэлгүй юм. Иймээс шүүгдэгч Э.Т-д холбогдох ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан хэргийг гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон ЭХТА-ийн 11.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг мөн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болгон хөнгөрүүлэн зүйлчилж, уг хэргийг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн өөрчлөлтийг шийтгэх тогтоол, магадлалд оруулж, энэ талаар гаргасан шүүгдэгч, түүний өмгөөлөгч нарын гаргасан гомдлыг хэсэгчлэн хангахаар шийдвэрлэсэн.

## Дүн шинжилгээ

ЭХТА-д заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг хэрхэн ойлгох нь чухал байна. Дээрх шийдвэрээс үзэхэд ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүчирхийллийг байнгын шинжтэй үйлдсэн бол гэмт хэрэг болно гэж тайлбарласан нь Эрүүгийн хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн харилцан уялдааг нэг мөр ойлгох практик хэрэглээнд ач холбогдолтой байх хэдий ч Эрүүгийн хуульд гэр бүлийн хүчирхийллийн хэлбэрийг тодорхой үйлдлээр хязгаарлан заасан тул УДШ-ийн энэ тогтоол Эрүүгийн хуульд нийцсэн эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Харин гэр бүлийн гишүүд хоорондын таaramжгүй харилцаа бүр гэр бүлийн хүчирхийлэл болохгүй байх талаар тайлбарласан нь анхан болон давж заалдах шатны шүүх хэргийн бодит нөхцөл байдалд үндэслэлтэй дүгнэлт хийхийг шаардсан шийдвэр болжээ.

**3) УДШ-ийн 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн №203 дугаар тогтоол**

Монгол Улсын иргэн, 1993 онд төрсөн, эрэгтэй, ял шийтгүүлж байгаагүй, ... овогт Б.Б нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт холбогджээ.

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх шүүгдэгч Б.Б-г ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож зургаан сарын хорих ялаар шийтгэсэн. Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар шүүгдэгч Б.Б-д холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон түүнийг цагаатгаж шийдвэрлэсэн.

Харин хяналтын шатны шүүх дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Анхан шатны шүүх Б.Б-г 2018 оны 12 дугаар сарын 2, 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдрүүдэд БЗД-ийн нутаг дэвсгэрт байрлах А хотхоны ... тоотод эхнэр Э.Д-г өшиглөж, цохиж зодсон, мөн 2019 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр “Хүүхдээ унтуул л даа, янхан минь” гэх зэргээр хэл амаар доромжлон гэдэс рүү нь өшиглөж зодох үйлдэл нь байнга давтагдаж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болох нь шүүх хуралдаанд хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар нотлогдож тогтоогдсон талаар хууль ёсны бөгөөд үндэслэлтэй дүгнэлт хийжээ. Шүүх шүүгдэгч Б.Б-гийн үйлдлийг ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар зүйлчлэн хуульд заасан төрөл, хэмжээний ял оногдуулж Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн байна.

Хэргийн үйл баримтаас үзэхэд шүүгдэгч Б.Б нь 2018 оны 12 дугаар сарын 2 болон 2019 оны 4 дүгээр сарын 16-ны өдрүүдэд эхнэр Э.Д-г зодсон нь шүүхийн хүчин төгөлдөр шийтгэврээр, 2019 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр эхнэр Э.Д-г зодсон үйлдэл шүүх хуралдаанд хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар тус тус тогтоогджээ. Хууль тогтоогч ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлүүдийн сэдэлт, зорилгыг тодорхойлсон боловч

уг үйлдлүүдийн хоорондох хугацааны хамаарлыг нарийвчлан тодорхойлоогүйгээс энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэхтэй холбоотой эрх зүйн маргаан үүссэн байх тул энэхүү эргэлзээ, маргааныг сэжигтэн, яллагдагч, шуугдэгчид ашигтай байх зарчмыг баримтлан дараах тайлбар, хууль хэрэглээний жишиг тогтоох үндэслэлтэй гэж үзэв.

Энэхүү гэмт хэргийн үндсэн шинж болох “байнга” нь тооны давтамжаас хууль зүйн ойлголт руу шилжихдээ хууль зүйн алдаагүй байх ёстой бөгөөд гэмт хэргийн шинжийг хангаж буй гурав ба түүнээс дээш удаагийн үйлдлийн хооронд зөрчилд хариуцлага хүлээлгэх хөөн хэлэлцэх хугацаа дуусаагүй байх нь тухайн үйлдлийг нэгтгэн дүгнэх хууль зүйн үндэслэл (легитим) болно. Зөрчлийн тухай хуулийн хөөн хэлэлцэх хугацааг хэрэглэх үндэслэл нь гурав ба түүнээс дээш удаа гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон зөрчлүүдийн нэг нь дангаараа гэмт хэргийн шинжийг хангахгүй тул Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг ашиглах боломжгүй. Харин үйлдэл болон зөрчлүүдийн нийлбэр Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэрэгт шилжиж байгаагаас үүдэлтэй юм.

Б.Б-гийн гурван удаагийн зөрчлийн тухайд тоо болон хууль зүйн шинжээрээ гэмт хэрэг гэж дүгнэх хууль зүйн шалтгаант холбоо үүссэн, тухайлбал, үйлдлүүдийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа тасарч өмнөх үйлдлүүдийг сүүлийн үйлдэлтэй нэгтгэж, эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл болсон гэж үзнэ. Дээрх үндэслэлээр анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хууль зүйн үндэслэлтэй гарсан гэж үзэж болно. Харин давж заалдах шатны шүүх Б.Б нь холбогдсон гэмт хэргийнхээ хоёр үйлдэлд баривчлах шийтгэл хүлээсэн байх тул гэр бүлийн хүчирхийллийг “байнга” үйлдсэн гэж дүгнэсэн нь учир дутагдалтай бөгөөд “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн шударга ёсны зарчмыг зөрчсөн гэж үзэж ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Б.Б-г цагаатгаж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлгүй болсон байна.

Ямар ч хүнийг үйлдсэн гэмт хэрэгт нь шүүхээс хуулийн дагуу эцэслэн шийтгэсэн буюу цагаатгасан тохиолдолд тэрхүү гэмт хэргээр дахин шүүх буюу шийтгэхийг хориглодог Double jeopardy (Ne bis in idem) гэсэн Эрүүгийн эрх зүйн онолын зарчмыг НҮБ-аас баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Ромын дүрмийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ тогтоосон бөгөөд Монгол Улс уг зарчмыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангидаа тухайллан хуульчилж тусгажээ.

Монгол Улс уг зарчмыг Эрүүгийн хуульдаа “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэж тусгасан нь Эрүүгийн хуулиар тогтоосон гэмт хэрэгт шүүхээс шийтгүүлсэн эсхүл цагаатгасан тохиолдолд шүүхээс эсхүл өөр шүүхээс дахин шийтгэхийг хориглосон агуулгыг илэрхийлсэн бөгөөд Зөрчлийн хуулиар шийтгэл оногдуулсан эсхүл оногдуулж болох зөрчил давтагдах зүй тогтлоороо нийгэмд аюултай үзэгдлийг гэмт хэрэгт шилжүүлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэж буй энэхүү гэмт хэргийн тохиолдолд дээрх зарчим хамааралгүй гэж үзнэ.

Зөрчилд шийтгүүлсэн нь нэг удаагийн тохиолдол бөгөөд тэрхүү зөрчлийн үйлдэл дангаараа гэмт хэргийн шинжийг хангаж чадахгүй ч өөр бусад ижил тохиолдлуудтай нэгдэж гэмт хэргийн шинжийг хангаж байгаа тохиолдолд зөрчилдөө шийтгүүлсэн нь хууль бус үйлдлийн цаана хамгаалагдаж буй харилцааг Эрүүгийн хуулиар хамгаалах зорилгыг хязгаарлах үндэслэл болохгүй.

Хамгаалагдаж буй харилцааны агуулга нь “Тэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийн “гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх”-доршино гэсэн зорилгоор тодорхойлох бөгөөд уг хуулийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль эсхүл Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх асуудлыг үйлдлийн давтамжийг харгалzan шат дараалж хүндрүүлсэн нь хууль тогтоогчийн үзэл санаа юм.

Эрх зүй нь зүй бус, хууль бус үзэгдлийг ямагт хүлээн зөвшөөрч болохгүй бөгөөд түүнд хариуцлага хүлээлгэх асуудлыг эрэмбэлэн илэрч буй аюултай түвшин, зүй тогтоос нь шалтгаалан эрүүжүүлэх, хариуцлагыг хүндрүүлэх зарчим, бодлого цөөнгүй бөгөөд энэхүү ойлголт, ухагдахууныг хууль тогтоогч тооцож, хуульчилсан байна.

Түүнчлэн ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1, 1.2, 1.3 дахь заалт болон Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан шинжүүдийн давхардаж буй хэсгүүд нь гэмт хэргийн шинжийг тодорхойлох үндэслэл болох бөгөөд аль нэг үйлдлийг гурав ба түүнээс дээш удаа эсхүл нийтдээ гурав ба түүнээс дээш удаа байх аль ч тохиолдол гэмт хэргийн шинжийг хангана.

Иймд прокурорын бичсэн эсэргүүцлийг хүлээн авч давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх хуралдаанаас шийдвэрлэжээ.

## Дүн шинжилгээ

УДШ-ийн энэхүү тогтоол нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан “гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх” гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг тодорхойлж, хууль хэрэглээний хувьд жишиг тогтоосон байна. Үүнд:

- “байнга” гэсэн шинж нь зөвхөн тоон утга биш бөгөөд хууль зүйн ойлголт болохын хувьд хөөн хэлэлцэх хугацаа, үйлдэл хоорондын шалтгаант холбоо, үр дагавартай байх ёстой.
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэг арга бол үйлдсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх тухай асуудал юм. Тиймээс гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн арга, сэдэлт, зорилго, хүчирхийллийн нөхцөл байдал зэргээс хамааруулан зөрчлөөс гэмт хэрэг болгон хууль зүйн үр дагаврыг хүндрүүлэхээр хууль тогтоогч хуульчилсан байна гэж УДШ тайлбарласан. Өөрөөр хэлбэл, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай

хуульд заасан нөхцөл байдлын үнэлгээ, аюулын зэргийн үнэлгээг мөрдөн шалгах ажиллагаанд заавал хийх ёстойг илтгэж байна.

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Ромын дүрэм зэрэг олон улсын баримт бичигт заасан *Ne bis in idem* зэрэг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг Монгол Улс Эрүүгийн хуульдаа “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” буюу шударга ёсны зарчим хэмээн хуульчилсан. Энэхүү шударга ёсны зарчим нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд хамааралгүй тул тус хуулийн дагуу шийтгүүлсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

#### 4) УДШ-ийн 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 342 дугаар тогтоол

Монгол Улсын иргэн, 1985 онд төрсөн, эрэгтэй, ял шийтгүүлж байгаагүй, ... овогт Г.Б нь ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт холбогджээ.

Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлийн 1.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч Г.Б-д холбогдох хэргийг “тэмт хэргийн шинжгүй” гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон, түүнийг цагаатгаж шийдвэрлэсэн байна. Тус шийдвэрт улсын яллагчийн зүгээс эсэргүүцэл бичсэний дагуу Дорнод аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх цагаатгах тогтоолыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцаан шийдвэрлэжээ.

Харин хяналтын шатны шүүх дараах байдлаар шийдвэрлэсэн байна. Үүнд: Анхан шатны шүүх прокуророос шилжүүлсэн хэргийн хүрээнд шүүгдэгчийн гэм бурууг хянан хэлэлцэж, шүүгдэгч Г.Б нь 2019 оны 12 дугаар сарын 2-ны орой Дорнод аймгийн Хэрлэн сум, ... дүгээр баг, ... тоот гэртээ согтуугаар эхнэр Д.А-тай маргалдах

үедээ түүнийг хогийн хутгуураар цохиж биед нь гэмтэл учруулсан, мөн 2015 оны 6 дугаар сар, 2017 оны 5 дугаар сар, 2017 оны 10 дугаар сар, 2018 оны 8 дугаар сарын 22-нд тус тус зодсон үйлдлийг ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгон, түүнийг цагаатгаж шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэл бүхий болжээ.

Шүүгдэгч Г.Б-гийн хувьд 2015 оны 6 дугаар сараас 2019 оны 12 дугаар сарын 2-ныг хүртэлх хугацаанд таван удаа эхнэр Д.А-гийн эрх чөлөөнд халдаж, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй үйлдэл хийсэн боловч тэдгээр үйлдлийн хооронд Зөрчлийн тухай хуульд заасан зургаан сарын хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн байх тул ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан “байнга” гэсэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн шинж үгүйсгэгдэж байна.

Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн шударга ёсны зарчим нь Эрүүгийн хуулиар ял шийтгүүлсэн хүнд тухайн гэмт хэрэгт дахин ял оногдуулахыг хориглосон агуулгыг илэрхийлэх бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж Зөрчлийн тухай хуулиар шийтгэл хүлээсэн хүн тухайн зөрчлийг удаа дараа үйлдэх нь дахин давтагдах шинжээрээ нийгэмд аюултай гэмт хэргийн шинжийг агуулж, Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрхийг ноцтой зөрчиж, илүү хүнд хор уршигт хүргэж болзошгүй үр дагаврыг хууль тогтоогч харгалзан гэр бүлийн хүчирхийлэл байнга үйлдэхийг гэмт хэрэгт тооцсон бөгөөд гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн хүн Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээсэн эсэх нь түүний үйлдлийг ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөхгүй тул энэ талаар давж заалдах шатны шүүхийн дүгнэлт зөв байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг үйлдлийнх нь давтамж, аюулын шинж чанараас нь хамааран түүнд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн шийтгэлээс Эрүүгийн хуулиар тогтоосон ял шийтгэл хүртэл шат дараалан хүндрүүлсэн нь Гэр

бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн “Гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, хохирогч, гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх”-ээс гадна хүчирхийлэл үйлдэгчийг нийгэмшүүлэх, хүний зөрчигдсөн эрхийг сэргээж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрүүгийн хариуцлагын зорилгыг давхар агуулсан болно.

Харин ЭХХШТХ-ийн 36.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Шүүгдэгч тухайн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй гэх үндэслэлээр цагаатгах тогтоол гарсан бол холбогдох шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаана” гэж заасан нь тухайн гэмт хэргийг жинхэнэ үйлдсэн хүнийг илрүүлэн, мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагаар хэргийг прокурорт буцаах агуулгатай бөгөөд энэ хэргийн хувьд Г.Б-гээс өөр хүнийг холбогдуулан шалгах үндэслэлгүй байхад анхан шатны шүүх хэргийг хэрэг бүртгэлтэд буцааж шийдвэрлэсэн нь буруу байна.

Иймд анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хэвээр үлдээх талаар шүүгдэгч Г.Б-гийн гаргасан гомдлыг хүлээн авч хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан давж заалдах шатны шүүхийн магадлал, мөн цагаатгах тогтоолын тогтоох хэсгийн 2 дахь заалтыг тус тус хүчингүй болгож, бусад заалтыг хэвээр үлдээх нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэжээ.

## Дүн шинжилгээ

УДШ-ийн энэхүү тогтоолын гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны талаарх дүгнэлттэй судлаачийн хувьд санал нийлэхгүй байна. Учир нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу зургаан сараар тооцож шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлд заасан 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулиар тодорхойлно”, 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй” гэсэн хууль ёсны зарчмыг зөрчсөн шийдвэр болсон гэж үзлээ. Өөрөөр

хэлбэл, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд заасан гэмт хэргийг хөөн хэлэлцэх хугацаагаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа тоологдох ёстой.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг шийдвэрлэж, хууль хэрэглээний хувьд жишиг тогтоосон УДШ-ийн дээрх шийдвэрүүдээс үзэхэд дараах дүгнэлтэд хүрч болохоор байна. Үүнд:

1. 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн УДШ-ийн 203 дугаар тогтоол гарах хүртэл анхан болон давж заалдах шатны шүүх гэр бүлийн хүчирхийллийн үйлдэл Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэгдсэн бол Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл “байнга” үйлдэх гэсэн шинжийг хангахгүй гэж дүгнэж байсан. Учир нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 5-д “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн шударга ёсны зарчим нь зөвхөн гэмт хэрэг бус зөрчил үйлдсэн этгээдэд хамаарна хэмээн хууль хэрэглээний хувьд алдаатай шийдвэр гаргаж байсан байна.
2. ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан “байнга” гэх шинж нь гурав болон түүнээс дээш гэсэн тоон утгаас гадна үйлдэл хоорондын шалтгаант холбоо, хөөн хэлэлцэх хугацаа зэрэг хууль зүйн үр дагавартай болохыг тодорхойлсон нь хэргийн зүйлчлэлд чухал нөлөө үзүүлсэн.
3. Гэр бүлийн гишүүд хоорондын хэрүүл, маргаан бүрийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг гэж үзэхгүй тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлд заасны дагуу хэргийн бодит байдлыг тогтоох шаардлагатай болохыг анхааруулсан.
4. Гэхдээ УДШ хөөн хэлэлцэх хугацааг Зөрчлийн тухай хуульд заасны дагуу тооцож болохоор тайлбарласан нь Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлд заасан хууль ёсны зарчмыг гажуудуулсан дүгнэлт болсон.

5. ЭХТА-ийн 11.7 дугаар зүйлд заасан гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан хүчирхийллийн хэлбэрээр ойлгоно гэж дүгнэсэн нь Эрүүгийн хуулийн тус зохицуулалтыг хэт өргөжүүлэн тайлбарласан шийдвэр болсон.

### **2.2.7. Ганцаарчилсан ярилцлага**

Ганцаарчилсан ярилцлагыг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төрийн болон төрийн бус байгууллагуудын мэргэжилтэн, судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчидтэй уулзаж хийсэн ба мөн утсаар ярилцлага хийсэн. Ярилцлагын явцад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтнууд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийн давхардлын талаар хангалттай ойлголт, мэдээлэлгүй байгаа нь ажиглагдав. Харин төрийн бус байгууллагын судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчид энэ талаар тодорхой санал, дүгнэлт илэрхийлсэн болно.

---

ХНХЯ-ны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Жендер, эмэгтэйчүүдийн хамгааллын бодлого зохицуулалт хариуцсан шинжээч Р.Нарантуяа: “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл [www.etuslamj.mn](http://www.etuslamj.mn) сайт дээр дэлгэрэнгүй байгаа. Манай яам бүх мэдээллээ оруулдаг”.

ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Б.Цэнгэлбаяр: “Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээг сар бүр [www.police.mn](http://www.police.mn) сайтад байршуулдаг тул холбогдох мэдээллийг тус цахим сайтаас аваарай”.

---

ГХУСАЗЗ-ийн ажлын албаны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Амарбаясгалан: “Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой мэдээлэл [www.cccp.mn](http://www.cccp.mn) сайт дээр дэлгэрэнгүй байгаа. Тэндээс тайлан, мэдээг харж болно”.

Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн захирал Н.Арвинтариа:  
“Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой хэд хэдэн асуудал байгаа. Үүнд:

1. Эрүүгийн хариуцлагын асуудал: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчилд баривчлах шийтгэх оногдуулдаг, харин гэмт хэрэгт тэнсэх эсхүл торгох ял оногдуулдаг. Тиймээс хариуцлага оновчтой биш байгаа.
2. Зүйлчлэлийн асуудал: “байнга” гэдэг шинжээс хамаарч гэмт хэрэг болдоггүй зөрчил болоод байдаг.
- В. Хөөн хэлэлцэх хугацаа: Гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах явцад хөөн хэлэлцэх хугацаа дууссан байдаг.
- Г. Үр дагаврын асуудал: Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд албадлагын арга хэмжээ хангалтгүй авагддаг. Зан үйл олгох албадан сургалт хийх шаардлагатай.
- Д. 2004 оны Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар эрхийг хязгаарлах арга хэмжээг иргэний хэргийн шүүхээр авч байсан боловч хэрэгжих механизм байхгүй байсан.
- Е. Санал: Зорчих эрхийг хязгаарлах ялыг Зөрчлийн тухай хуульд оруулах”.

---

Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн өмгөөлөгч (нэрээ нууцлахыг хүссэн болно):

“Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг мөрдөгч, прокурор бүрэн дүүрэн шалган тогтоож чаддаггүй. Мөн өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх явцад хохирогч гомдлоосоо татгалзах тохиолдол үүсдэг. Зөрчлийн хэрэг хөөн хэлэлцэх хугацаа дууссан байдаг, зарим хэрэгт хөөн хэлэлцэх хугацааг Зөрчлийн тухай хуулийн дагуу зургаан сараар тооцож “байнга” гэсэн шинжид хамааруулахгүй байгаа. Мөн Зөрчлийн тухай хуулиар 30 хүртэл хоног баривчлах шийтгэл оногдуулж байгаа хэр нь Эрүүгийн хуулиар торгох эсхүл тэнсэх арга хэмжээ авч байгаа нь эрүүгийн хариуцлага шударга бус байгааг харуулдаг.”

---

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор (нэрээ нууцлахыг хүссэн болно):

“Мөрдөгч хэргийн ачааллаас хамаарч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг, зөрчлийг бүрэн мөрдөн шалгаж чаддаггүй. Учир нь аюулын зэргийн болон нөхцөл байдлын үнэлгээ хийхгүй байх, дутуу хийх зэрэг алдаа гардаг. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчлийг гурван удаа үйлдсэн бол гэмт хэрэг болж байгаа”.

Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч (нэрээ нууцлахыг хүссэн болно):

“Тэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зөрчил, гэмт хэрэг хоёр бүрэлдэхүүний хувьд ялгаагүй, зөвхөн “байнга” гэсэн тоон утгаар ялгагдаж байгаа. 2020 оны 11 дүгээр сараас эхлэн зөрчлийн үйлдлийг байнга гэсэн гурван удаагийн гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжид хамааруулан шийдвэрлэж байна. Үйлдэл хоорондын хугацааг Зөрчлийн тухай хуулийн дагуу зургаан сараас хэтрэхгүй байхаар авч үзэж буй. Түүнээс өмнө “нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэсэн зарчмын дагуу тусад нь авч үздэг байсан”.

## ГУРАВ. ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ ҮЙЛДЭХ ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ БУСАД УЛС ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ОНЦЛОГ

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдлыг бууруулах, зогсоох талаар дэлхийн улс орнууд дотоодын хууль тогтоомж, дүрэм журам боловсруулах, тэдгээрийг өөрчлөн сайжруулах, түүнчлэн гэрээ хэлэлцээр, конвенц байгуулан төлөвлөгөө боловсруулах зэргээр хамтран ажиллаж, орчин цагт олон арга хэмжээ авч, янз бүрийн оролдлого хийсээр байгаа билээ. Гэхдээ нэгэн цаг үед гэр бүлийн хүчирхийлэл нь гэмт хэрэг хэмээн тооцогддоггүй, тэр ч бүү хэл “хэвийн” үзэгдэл мэт үздэг байсныг энд дурдах нь зүйтэй болов уу. Чухам энэ шалтгаан, тогтсон “соёлын” улмаас одоо ч зарим уламжлалт соёлт гэр бүл, нийгэмд гэр бүлийн хүчирхийллийг байж болох үзэгдэл мэтээр харж, хохирогчид хүчирхийлэл үйлдэгчээс аиж эмээн хүчирхийлэлд өртсөөр байгаа үзэгдэл түгээмэл байна.

Гэр бүлийн хүчирхийлэл гэдэг нь хүлээн зөвшөөрөх боломжгүй, бусад гэмт хэргийн нэгэн адил нийгэмд аюултай үзэгдэл мөн гэдгийг дөнгөж XX зууны төгсгөл үеэс улс орнууд хүлээн зөвшөөрч, энэ талаар хэлэлцэж эхэлсэн болох нь тухайн үеийн зарим ном, сурах бичиг, судалгааны ажил зэргээс харагдаж байна. Үүний нэгэн жишээ нь 1993 онд НҮБ-аас гаргасан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төлөвлөгөөний гарын авлага” юм. Энэхүү гарын авлагад гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэгт тооцож хуульчлах хэрэгтэй юу эсхүл шаардлагагүй юу хэмээх асуудалд улс орнууд, эрдэмтэн судлаачид өөр өөрийн байр сууринаас ханддаг тухай дурдаад зарим шалтгаан, үндэслэлийг дараах байдлаар авч үзсэн байна.



Зураг 1. Германы уран бүтээлч Tonie Meilhamer-ын бүтээл

Зарим хүн гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд заавал Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх шаардлагагүй хэмээн үздэг. Энэ талыг баримтлагчид эвлэрүүлэх, хэлэлцэх аргыг илүүд үздэг бөгөөд баривчлах, яллах, хэрэг хянан шийдвэрлэх процесс бүхий хууль сахиулах тогтолцооноос зайлсхийхийг эрмэлзэж, нийгмийн халамж болон эмчилгээний аргад үндэслэхийг дэмждэг байна. Хэрэв Эрүүгийн хууль заавал үйлчлэхээр бол хамгийн эцсийн арга хэмжээ байх өсхүл хүнд гэмт хэрэгт үйлчлэх нь зүйтэй хэмээн үздэг байна.

Негеө хэсэг нь хуулийн хамгаалалтын зарчимд үндэслэсэн арга барилыг илүү дэмждэг. Өөрөөр хэлбэл, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хууль нь хамгаалдаг байхыг тэд хүсдэг. “Хохирогч хэн байхаас үл шалтгаалан хүчирхийлэл нь гэмт хэрэг мөн” хэмээх үзэл баримтлалтай хүмүүс энэ төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцох хандлагыг илүү дэмждэг байна. Тэд гэр бүлийн хүчирхийллийг бусад хүчирхийллийн гэмт хэргийн нэгэн адил нухацтай авч үзэх ёстой хэмээн үздэг бөгөөд энэ нь нийгмийн шинжтэй урт болон богино хугацааны үр дагаврууд үүсгэх, гэр бүлийн доторх итгэлцлийг үгүй болгох зэрэг сөрөг үр дагаврыг анхаарах нь зүйтэй гэж үздэг.

Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг болгон хуульчлахгүй байх нь зүйтэй хэмээн үздэг хэсгийн үндэслэл нь:

1. Эрүүгийн хууль тогтоомж нь засан хүмүүжүүлэх бус, шийтгэхэд чиглэж анхаардаг.
2. Эрүүгийн эрх зүй нь өнгөрсөнд хийсэн үйлдлийг авч үздэг бөгөөд ирээдүйд хийгдэх үйлдэлд анхаарал хандуулдаггүй.
3. Олон улс орны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хохирогчийн хүсэл зоригийг үл тоодог.
4. Эрүүгийн эрх зүйн тогтолцоо нь хохирогчид дэмжлэг туслалцаа үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг дахин хүчирхийлэл үйлдэхгүй байхад “сургах” зэрэгт чиглэсэн хөтөлбөр, үйл ажиллагаа хэрэгжүүлэх нь ховор байдаг.

5. Цагдаа, улсын яллагч, шүүгчид нь хуулийн хэрэгжилтийг хангах, хянах эрх бүхий субъектүүд билээ. Гэтэл тэдний ихэнх нь өмнө нь гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг хэмээн үзэх нь битгий хэл “ноцтой асуудал” гэж үздэггүй байсан бөгөөд хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, яллахдаа дургүй, хойрго ханддаг байсан байна.
6. Цагдаа, прокурор болон шүүгчид гэр бүлийн хүчирхийллийн үйлдлийг хүлээн авч хянадаг ч үйлдэл бүрд эрүүгийн ял шийтгэл оногдуулдаггүй. Хүчирхийлэл үйлдэгчийг гэмт хэрэг үйлдсэн хэмээн үзэхэд хангалттай нотлох баримт байхгүй байх тохиолдол гардаг.
7. Хүчирхийлэл үйлдэгч баривчлагдаж, ял шийтгэл авсан ч энэ нь “өчүүхэн” бага хэмжээний шийтгэл байх нь элбэг.
8. Ялтай байдал болон зарим тодорхой шийтгэлүүд нь хүчирхийлэл үйлдэгчийг яллаад зогсохгүй хохирогч, түүний гэр бүлийг ч мөн шийтгэх тохиолдол байдаг.
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дунд хүчирхийлэгчийг цагаатгах эсхүл ял оногдуулах аль ч шийдвэр гарсан хүчирхийлэл дахин давтагдах боломжтой бөгөөд хохирогч тэр үед аюулд өртөхгүй гэх баталгаа байхгүй юм.
10. Хүчирхийлэл үйлдэгчид хорих ял оногдуулсан ч хохирогч нь түр хугацаанд л айdasгүй, тайван байх ба хүчирхийлэгч нь ялаа эдэлж дууссаны дараа хохирогчийг бүр “зэрлэг”-ээр хүчирхийлэх боломжтой.
11. Гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэг болгон хуульчлах нь хохирогчид сөрөг үр дагавар үүсгэх боломжтой. Тухайлбал, эвлэрүүлэн хэлэлцэх хандлагыг дэмждэг уламжлалт гэр бүлийн соёлтой нийгэм, улс орон эсхүл хүн амын цөөнх дунд гэр бүлээсээ тусгаарлагдах, нийгэм, хүрээллээсээ гадуурхагдан “шахагдах” сөрөг үр нөлөөг хохирогчид үзүүлэх магадлалтай.

12. Зарим судалгааны үр дүнд гэр бүлийн хүчирхийлэл дахин давтагдахаас сэргийлэх хамгийн үр дүнтэй арга нь эвлэрүүлэх, эмчлэн сувилах явдал хэмээн зөвлөсөн.

Гэр бүлийн хүчирхийллийг зогсоох хамгийн “зөв” арга нь гэмт хэрэг болгон хуульчлах явдал хэмээн үздэг хэсгийн үндэслэл нь:

1. Хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийтгэл оногдуулах зэрэг нь нийгмийн зүгээс буруутай этгээдийг шүүмжилж, буруушааж буйг илтгэн харуулдаг. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч нь өөрийнхөө үйлдлийн төлөө хариуцлага хүлээх учиртай.
2. Гэр бүлийн гишүүдийн хооронд үйлдэгдэж буй гэмт хэрэг нь гудамжинд үл таних хүмүүсийн хооронд үйлдэгдсэн гэмт хэргийн нэгэн адил тооцогдохыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар тогтоодог.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хохирогчийг төрийн хамгаалалтад авах эрхийг баталгаажуулж өгдөг. Хүчирхийлэгч, хохирогч хоорондын гэр бүлийн харилцааг хадгалж үлдэх хэрэгцээ, гэр бүлийг хагацуулахгүй байх шаардлагаас уртаж хохирогчийн хэрэгцээ яригдах учиртай.
4. Хууль нь сурган хүмүүжүүлэх чухал үүрэг гүйцэтгэдэг. Хууль, дүрмээр хүний зан байдлыг өөрчлөх боломжтой. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдлыг гэмт хэрэг мөн хэмээн хүлээн зөвшөөрч хуульчлах нь өөрөө чухал ач холбогдолтой. Өмнө нь гэр бүлийн хүчирхийллийг ойшоохгүй, үл тоодог байсан. Гэр бүл дэх хүчирхийлэл үгүй болох эсэх нь энэхүү хүчирхийлэл нь байж болшгүй, эвлэрэх боломжгүй зүйл юм гэдгийг гэр бүлийн гишүүд харилцан ойлголцооос шалтгаална.
5. Баривчлах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, ял оногдуулах зэрэг нь хүчирхийлэгчийн гэмт хэрэг үйлдэх сэдлийг таслан зогсооход шууд нөлөөтэй. Зарим судалгаанд дурдсанаар хууль хэрэгжүүлэхээр цагдаа оролцох, түүний

дараа хянан шийдвэрлэх, ял оногдуулах ажиллагаа явагдах нь хүчирхийллийн үйлдлийг таслан зогсоох хамгийн үр дүнтэй арга төдийгүй хүчирхийлэл үйлдэгчийн цаашдын үйлдэлд хүчтэй нөлөө үзүүлдэг гэж үздэг байна. Судалгааны үр дүнгээс харахад хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах, ял оногдуулах механизмыг хэрэгжүүлсний үр дүнд тухайн хүчирхийлэгчийн ижил төрлийн гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэл буурсан.<sup>85</sup>

Улс орнууд болон эрдэмтэн, судлаачид дээрх байдлаар гэр бүлийн хүчирхийллийг гэмт хэрэгт тооцох нь зөв, буруу тухай хэлэлцэж, өөр өөрсдийн зохицуулалтыг тусган хуульчилсны дараа зарим нь сайн, зарим нь муу үр дүнд хүрч байгаа нь туршлагаас харагдаж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх явдлыг таслан зогсоосон, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхээс бүрэн урьдчилан сэргийлсэн улс орон байхгүй ч авч хэрэгжүүлж буй зарим нэг арга хэмжээ нь эерэг үр дагавар авчирч байгаа улс орны жишээ цөөнгүй байгаа юм. Тухайлбал, Европын Холбооны дийлэнх улс орон, түүнчлэн Европын Холбоо институтийнхээ хувьд “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай конвенц” буюу Станбулын конвенцод нэгдэн орсноор гишүүн орнууд хууль тогтоомждоо тодорхой өөрчлөлт оруулах үүрэг хүлээн хүчирхийлэлтэй, тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх олон улсын стандарт тогтоосон юм. Тус Конвенц нь мянга мянган хүчирхийлэлд өртөгсдийн амь насыг аврах, гарч болох сөрөг үр дагавраас сэргийлэх чухал хэрэгсэл болж чадахыг Amnesty International дараах байдлаар онцолжээ.<sup>86</sup> Үүнд:

<sup>85</sup> L.W. Sherman and R.A. Berk, The specific deterrent effects of arrest for domestic assault, American Sociological Review, No.49, 1985, p.261.

<sup>86</sup> <https://www.amnesty.org/en/latest/news/2021/05/heres-why-the-istanbul-convention-saves-lives/>


- *Тус Конвенц нь эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд мөрдөгдөх “алтан стандарт” юм.*

Станбулын конвенц нь эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгддэг хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийн эсрэг тусгайлан боловсруулагдсан, хамгийн олон улс орныг хамарсан хэлэлцээр юм. Тус Конвенцоор Европын орнуудын Засгийн газар хүчирхийллийн эсрэг тэмцэхдээ мөрдөх шаардлагатай суурь стандартууд тогтоож өгсөн. Конвенцод нэгдэн орсон улс орнууд хамгаалах болон дэмжлэг үзүүлэх дараах үйлчилгээнүүдийг нэвтрүүлэх үүрэг хүлээдэг. Үүнд:

- Хангалттай тооны хамгаалах байр;
- Бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд зориулсан төв;
- 24/7 цагийн үнэ төлбөргүй тусlamжийн утас;
- Хохирогчдод үзүүлэх сэтгэл зүйн зөвлөгөө, эмнэлгийн тусlamж зэрэг орно.

- *Ялгаварлан гадуурхалгүйгээр бүх эмэгтэйчүүд, охидыг хамгаалдаг.*

Европын орнуудад шүүмжлэл, гадуурхалттай тулгардаг ЛГБТ+ буюу бэлгийн цөөнхүүд ч мөн гэр бүлийн бусад хүчирхийллийн хохирогчдын нэгэн адил эрхээ хамгаалуулах, хохирлоо нөхөн төлүүлэх боломжийг энэхүү Конвенц олгосон. Тус Конвенц нь дүрвэгч болон цагаач эмэгтэйчүүдийн эрхийг мөн хамгаалахад чиглэсэн тусгайлсан зохицуулалттай болохыг энд дурдах нь зүйтэй. Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн цагаач эмэгтэйчүүд хүчирхийлэгч хамтрагчийнхаа оршин суух статусаас хамааралтай тохиолдолд тухайн хохирогчид бие даан оршин суух зөвшөөрөл олгох боломж олгосон.



Зураг 2. Станбулын Конвенцод гарын үсэг зурсан, нэгдэн орсон орнууд

- Конвенц нь өрөөсгөл болон хэвшмэл ойлголтыг халахад чиглэсэн.

Жендерийн хэвшмэл ойлголт болон буруу ташаа хандлага, практик нь эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдээс “дорой” гэх дөрд үзэх үзлийг улам лавшуулж байна. Арьс өнгө, гарал угсаа, нийгмийн гарал, нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, шашин шүтлэг болон гэрлэлтийн статус зэргээсээ шалтгаалан ялгаварлан гадуурхалтад өртөж буй эмэгтэйчүүдийн хувьд дээрх хэвшмэл ойлголтын золиос болох нь элбэг байна. Станбулын конвенц нь дээрх хэвшмэл, буруу ойлголтын эсрэг “хүчирхийлэл болон харгис хэрцгий үйлдэлд өршөөл гэж үгүй” гэх үзэл санааг тусгажээ.

Засгийн газар эдгээр хэвшмэл ойлголтоос бий болсон жендерийн талаарх ойлголт, хандлага зэргийг өөрчлөх, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг хэвийн үзэгдэл мэтээр хүлээн авч буй нийгмийн хандлагыг залруулахын тулд урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй. Хэдийгээр харьцангуй цөөн ч гэсэн эрэгтэйчүүд ч мөн зарим хэлбэрийн гэр бүлийн

хүчирхийлэлд өртдөг тул Конвенц нь Засгийн газруудыг энэ төрлийн хүчирхийллийг мөн хүлээн зөвшөөрч, хүйс харгалзахгүйгээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдыг хамгаалахыг уриалсан байна.

- Энэхүү Конвенц нь өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн хүний эрхийн баримт бичиг юм.

Европ даяар эмэгтэйчүүдийн эсрэг үйлдэгдэх хүчирхийлэл нэмэгдэж байгаа бөгөөд хамтарсан цогц арга хэмжээ авах хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг олон улс орон болон иргэний нийгмийн байгууллага хүлээн зөвшөөрч, дэлхий даяар хүчирхийлэлд өртсөн хэн ч байсан ижил түвшний хамгаалалт эдлэх боломж олгохын тулд Станбулын конвенцыг боловсруулсан. Конвенц нь улс орны дотоодын эрх зүйн зохицуулалтыг давсан, дэлгэрүүлсэн баримт бичиг юм.

Тус Конвенц нь 2014 оны 8 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон бөгөөд Amnesty International нь тус Конвенцыг боловсруулахад оролцсон байгууллагуудын нэг. Тус Конвенцод Европын 40 гаруй улс орон гарын үсэг зурсан бөгөөд Европын Холбоо мөн институцийнхээ хувьд нэгдэн орсон билээ.

- Станбулын конвенцод маргаантай, эсрэгцсэн агуулга бүхий зохицуулалт байхгүй.

Тус Конвенцод заасан «хүйс» гэх нэр томъёоны талаар ташаа мэдээлэл түгээх захиалгат ухуулга явуулж, энэхүү Конвенц нь уламжлалт «гэр бүл» гэсэн ойлголтыг алдагдуулж байна гэсэн агуулга бүхий хуурамч мэдэгдлийг зарим улсын Засгийн газар, нийгмийн бүлгүүд хийж байгаагаас шалтгаалан цөөн хэдэн улс орон Конвенцыг соёрхон баталж чадахгүй байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Словак Улс, Унгар Улсын парламент Конвенцыг соёрхон батлах тухай санаачилгыг няцаасан бол Бүгд Найрамдах Болгар Улсын Үндсэн хуулийн шүүх уг Конвенцыг Үндсэн хуульд нь нийцэхгүй байна хэмээн үзжээ. Конвенцод гарын үсэг зурж, соёрхон баталсан анхны улс болох Бүгд Найрамда Турк Улс нь

2021 оны 3 дугаар сард уг Конвенцоос гарч байгаагаа зарлан, уг Конвенц нь ижил хүйстнүүдийн харилцааг нийгэм дэх “хэвийн” үзэгдэл болгоход чиглэсэн бөгөөд энэ нь тус улсын нийгмийн болон гэр бүлийн үнэт зүйлстэй харшилж байна хэмээн үзжээ.

- Конвенц нь олон хүний эрхийг хамгаалах өөрчлөлт авчирч буй баримт бичиг мөн.

Дэлхий даяар олон улс орны эмэгтэйчүүдийн эрхийн төлөө тэмцэгч байгууллагууд энэхүү Конвенцыг жишиг баримт бичиг болгон ашиглаж, хүний эрхийн төлөө, хүчирхийллийн эсрэг ажлуудыг амжилттай зохион байгуулсаар байна. Хачирхалтай нь Конвенцыг эсэргүүцэж, ташаа ойлголтыг тарааж буй улс орнууд, тухайлбал, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Польш Улсын иргэд хүйсийн эрх тэгш байдал болон эмэгтэйчүүдийн хүчирхийллийн эсрэг Конвенцыг дэмжин тэмцэж нэгдэж байна.

Конвенцын үр дүнд зарим эерэг өөрчлөлт гарч байна. Тухайлбал, Бүгд Найрамдах Финланд Улс Станбулын конвенцод нэгдэн орсноор гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдын хамгаалалтын байрыг санхүүжүүлэх нь төрийн үүрэг болсон. Бодит байдалд аль ч улс орон гэр бүлийн хүчирхийллээс ангид байх боломжгүй байгаа бөгөөд өөрчлөлтөд хүрэхийн тулд урт зам туулах шаардлагатай. Гэсэн хэдий ч Конвенцод гарын үсэг зурж, соёрхон баталсан Засгийн газрууд хүчирхийллийг таслан зогсоох арга хэмжээ авч, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах хүсэл зориг төрд байгаа гэдгийг илэрхийлсэн хүчтэй дохиог дэлхий нийтэд хүргэж байгаа юм.

Дээрх байдлаас дүгнэхэд Станбулын конвенц нь гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод зориулсан хамгаалалтын байр байгуулах, тусlamжийн утас нэвтрүүлэх, сэтгэл зүйн тусlamж үзүүлэх зэргээр хамгаалалтын тогтолцоог сайжруулах, түүнчлэн дотоодын хууль тогтоомж, дүрэм, журамдаа Конвенцод нийцүүлэн холбогдох өөрчлөлт оруулах үүргийг улс орнуудад хүлээлгэдгээрээ хүчирхийллэлд өртсөн эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах сайн баримт бичиг болсон хэмээн үзэж болохоор байна.

Түүнчлэн тус Конвенцод нэгдэн орсон талууд Конвенцын зохицуулалтыг хэрхэн нэвтрүүлж, дагаж мөрдеж байгаад хяналт тавих, дүгнэлт зөвлөмж өгөх үүрэг бүхий хараат бус мэргэжлийн байгууллага болох GREVIO (Group of Experts on Action against Violence against Women and Domestic Violence - Эмэгтэйчүүдийн эсрэг болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны шинжээчдийн бүлэг) үйл ажиллагаа явуулдаг нь тус Конвенцын хэрэгжилтийг үр өгөөжтэй, бодитой байхад анхаарч буйн нэг хэлбэр юм. Энэхүү байгууллага нь тус Конвенцод нэгдэн орсон улсуудын нөхцөл байдалд хяналт тавьж, дүгнэлт, зөвлөмж өгсөн байх бөгөөд энэ тухай тайланг 2016 онд нийтэлсэн байна. Тус тайландаа улс орон бүр хууль тогтоомж, хамгаалалтын арга хэмжээндээ ямар өөрчлөлт хийх, юуг нэмж тусгах шаардлагатай зэрэг нарийн зөвлөмж өгсөн байх бөгөөд хуулийн зохицуулалтын үүднээс Бүгд Найрамдах Австри Улсыг “сайн” зохицуулалттай хэмээн үзсэн нь тайландаа тусгагджээ. Гэвч Австрийн Эрүүгийн хуульд сэтгэл зүйн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг болгон зохицуулаагүй байгаа нь шүүмжлэлтэй тал болох тухай тайландаа дурдсан байна. GREVIO-гийн тайлангаас харвал Бүгд Найрамдах Франц Улсын тайландаа сэтгэл зүйн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилж өгсөн тухай дурдсанаас харвал Австриас дэвшилтэй зохицуулалттай байна хэмээн дүгнэхээр байна. Тэгвэл Станбулын конвенцод нэгдэн орсон Европын орнуудын сайн туршлагыг энэхүү Конвенцод нэгдэн ороогүй улс орны жишээтэй харьцуулж, ямар практик илүү үр дүнтэй байх, хуулийн болон хамгаалалтын зохицуулалт хэрхэн тусгагдах нь зүйтэй талаар судлан дүгнэлт өгөх нь зүйтэй хэмээн үзсэний дүнд Бүгд Найрамдах Австри Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Оросын Холбооны Улс болон Япон Улсын жишээ, туршлагыг авч үзлээ.

### **3.1. БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ УЛС**

Өмнө дурдсанчлан Станбулын конвенцыг гишүүн орнууд хэрхэн хэрэгжүүлж байгаад GREVIO хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт хийн санал зөвлөмж өгдөг. Гишүүн орнууд эмэгтэйчүүдийн эсрэг

үйлдэгддэг хүчирхийлэл, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж буй тухай дэлгэрэнгүй тайлангаа тус Конвенцын 68-р зүйлийн дагуу GREVIO-д хүргүүлдэг байна.

Бүгд Найрамдах Австри Улс (цаашид “Австри Улс” гэх)-ын GREVIO-д хүргүүлсэн 2016 оны тайланд дурдсанаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг зохицуулсан хэд хэдэн хууль тогтоомж байдаг байна. Эдгээр нь тус улсын Эрүүгийн хууль (StGB), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай (StPO), Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай (Bundesgesetz zum Schutz vor Gewalt in der Familie), Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай (ZPO) зэрэг хуулиуд юм.<sup>87</sup> Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хуультай уялдан Иргэний хууль тогтоомж, Аюулгүй байдлыг хангах цагдаагийн үйл ажиллагааны тухай хууль, түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль зэрэгт гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай зохицуулалтууд тусгагдсан байдаг.

Австри Улсын Эрүүгийн хууль нь Станбулын конвенцод заасан дийлэнх гэмт хэргийг тусган зохицуулсан байдаг ажээ. Сэтгэл зүйн хүчирхийллийн гэмт хэргээс бусад Конвенцын 33-40-р зүйлд заасан бүх гэмт хэрэг тус улсын Эрүүгийн хуулийн нэг эсхүл хэд хэдэн заалтад тусгалаа олсон байна. Дээрх гэмт хэргийн зарим нь Станбулын конвенц батлагдахаас нэлээд өмнө Эрүүгийн хуульд тусгагдсан байсан нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх Австри Улсын практик ямар шинэлэг болохыг харуулж байгааг GREVIO-ийн тайланд дурджээ.<sup>88</sup> Тухайлбал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн үед элбэг тохиолддог үйлдэл болох “үргэлжилсэн хүчирхийллийн үйлдэл”-ийг 2009 онд гэмт хэрэг (Эрүүгийн хуулийн 107b зүйл) болгон хуульчилсан байжээ. Гэр бүлийн харилцаан дахь хүчирхийллийн үйлдэл тус бүрийг авч үзэхийн оронд 107b-д заасан гэмт хэргийг хуульчилснаар

<sup>87</sup> Report submitted by Austria pursuant to Article 68, paragraph 1 of the Council of Europe Convention on preventing and combating violence against women and domestic violence, p.39. <https://rm.coe.int/16806ee8b2>

<sup>88</sup> GREVIO baseline evaluation report Austria, 2017, p.39. <https://rm.coe.int/grevio-report-austria-1st-evaluation/1680759619>

гэмт хэрэгтнийг гэр бүлийн хүчирхийллийн үргэлжилсэн гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял оногдуулах боломж олгодог байна. Тус гэмт хэргийг үйлдсэн этгээдэд гурав хүртэлх жилийн хорих ял оногдуулдаг бөгөөд хүндруүлэх нөхцөл байдал байгаа тохиолдолд зургаан сараас таван жил эсхүл арваас хорин жил хүртэлх хугацаагаар хорих ял оногдуулж болохоор хуульчилсан.<sup>89</sup>

Австри Улсын Эрүүгийн хуульд зарим гэмт хэрэгт хүндруүлэх нөхцөл байдлыг тухайллан зааж өгсөн байdag. Үүнээс гадна тус улсын Эрүүгийн хууль нь Станбулын конвенцод заасан шаардлагыг бүрэн хангасан, тусгай хүндруүлэх нөхцөл байдлуудын жагсаалт (Эрүүгийн хуулийн 33-р зүйл) агуулдаг. Энэхүү зохицуулалтын дагуу одоогийн болон хуучин эхнэр, нөхөр, хамтрагчийнхаа эсрэг (хүчирхийлэл үйлдэгч хүчирхийллийн шинжтэй үйлдэл хийх үедээ хохирогчтой хамт амьдарч байсан бол) үйлдсэн амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, бэлгийн хүчирхийлэл зэрэгт ялыг хүндруүлэн оногдуулдаг байна.<sup>90</sup>

Тус улс сэтгэл зүйн хүчирхийлэл үйлдэхийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй тул хууль сахиулах байгууллага хүчирхийллийг даамжууллахгүйн тулд яаралтай хориг тавих тухай захирамж (Emergency barring order) гарган хүчирхийлэл үргэлжлэхээс сэргийлдэг байна. Энэхүү хориг тавих эрх хэмжээний тухай Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хуульдаа заасан байdag ажээ.

Гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах тухай хууль нь 1997 оны 5 дугаар сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд 2000, 2004 зэрэг онд хэд хэдэн удаа нэмэлт өөрчлөлт оржээ. Тус хуулийн дагуу цагдаа нь хүчирхийлэл үйлдэгчийг хохирогчийн оршин сууж буй газарт нэвтрэхийг хориглох, хэрэв хүчирхийлэл үйлдэгч сайн дураараа тухайн газрыг орхихгүй бол хүчээр гаргах зэрэг арга хэмжээ авах эрх хэмжээтэй байна (энэхүү эрх хэмжээнийхээ

<sup>89</sup> Report submitted by Austria pursuant to Article 68, paragraph 1 of the Council of Europe Convention on preventing and combating violence against women and domestic violence, p.44.

<sup>90</sup> Мөн тэнд, 49 дэх тал.

хүрээнд өмнө дурдсан хориг тавих захирамж буюу Emergency barring order гаргадаг байна).<sup>91</sup> Энэхүү хориг тавих хугацаа нь хоёроос дөрвөн долоо хоног хүртэлх хугацаанд үргэлжлэх боломжтой<sup>92</sup> бөгөөд хэрэв хохирогчид урт хугацааны хамгаалалт хэрэгтэй бол шүүхэд хандан захирамж гаргуулах боломжтой. Хохирогч хүчирхийлэл үйлдэгчийг хажуудаа байхыг хориглосон захирамж гаргуулах хүсэлтээ илэрхийлэхдээ цагдаад урьдчилан мэдэгдэх шаардлагагүй бөгөөд хуульчийн туслалцаагүйгээр, үнэ төлбөргүй гаргах боломжтой. Шүүхээс гаргасан захирамжийг хүчирхийлэл үйлдэгч зөрчсөн тохиолдолд үүнийг захиргааны зөрчил хэмээн үзэж 500 хүртэлх еврогоор торгох бөгөөд үргэлжлүүлэн зөрчсөөр байвал баривчлах хүртэл арга хэмжээ авах зохицуулалттай.<sup>93</sup>

Дээрх жишээнээс дүгнэхэд тус улс нь гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчлаагүй байсан бөгөөд Станбулын конвенцод нэгдэн орсны дараа ч мөн Эрүүгийн хууль дахь тус зохицуулалтаа хэвээр үлдээсэн байна. Харин энэ төрлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд хүндруүлэн авч үзэхээр Эрүүгийн хуульдаа заасан байгаа нь өөрчлөлт оруулах шаардлагагүй, оновчтой зохицуулалт болох нь Австри Улсын тайланд хийсэн GREVIO-гийн дүгнэлт, зөвлөмжөөс харагдаж байна.

Станбулын конвенц нь өмнө дурдсанчлан, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хууль эрх зүйн орчин, хамгаалалт, туслалцаа үзүүлэх ажиллагаа ямар байх ёстой тухай стандарт, норм тогтоож байгаа баримт бичиг бөгөөд Конвенцод ч мөн гэр

<sup>91</sup> Аюулгүй байдлыг хангах цагдаагийн үйл ажиллагааны тухай хуулийн 38а-р зүйл.

<sup>92</sup> EMERGENCY BARRING ORDERS IN SITUATIONS OF DOMESTIC VIOLENCE: ARTICLE 52 OF THE ISTANBUL CONVENTION A collection of papers on the Council of Europe Convention on preventing and combating violence against women and domestic violence, 2017, p.16. <https://rm.coe.int/article-52-convention-istanbul-english-version/168073cae6#:~:text=Criminal%20law%20emergency%20barring%20orders&text=-For%20example%2C%20in%20Austria%20the,a%20civil%20law%20protection%20order>.

<sup>93</sup> Report submitted by Austria pursuant to Article 68, paragraph 1 of the Council of Europe Convention on preventing and combating violence against women and domestic violence, p.55.

бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчлах талаар зөвлөдөггүйг энд онцлох нь зүйтэй.

### 3.2. БҮГД НАЙРАМДАХ ФРАНЦ УЛС

Бүгд Найрамдах Франц Улс (цаашид “Франц Улс” гэх)-д гэр бүлийн хүчирхийллийг дараах байдлаар ангилан авч үздэг байна. Үүнд:

1. Бие махбодын (түлхэх, цохих, боомилох, хазах, түлэх зэрэг);
2. Аман (доромжлох, заналхийлэх, орилох);
3. Сэтгэл санааны (айлгах, доромжлох, шинэ танилтай болохыг нь хориглох гэх мэт.);
4. Бэлгийн (бэлгийн хүчирхийлэл, хүчиндэх);
5. Эдийн засгийн (зарлагыг нь хянах, ажил эрхлэхийг хориглох зэрэг);
6. Бичиг баримтыг нь (паспорт, эрүүл мэндийн дэвтэр, диплом гэх мэт) хурааж авах;
7. Цахим хүчирхийлэл (цахим тохуурхал, цахим мөрдлөг гэх мэт.)

Дийлэнх тохиолдолд гэр бүлийн хүчирхийлэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэдэг бөгөөд зөвхөн зарим төрлийн хүчирхийлэлд захиргааны хариуцлага оногдуулах үндэслэлтэй байдаг байна. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 1992 оны Эрүүгийн хуулийн 222.1-ээс 222.14 дүгээр зүйлүүдэд хүний бие махбод, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг үйлдэхдээ өөрийн төрсөн эсхүл хууль ёсны асран хамгаалагч, эцэг, эх, үр хүүхэд эсхүл нэг гэрт байнга хамт оршин суудаг хүний эсрэг үйлдсэн бол тухайн гэмт хэргийг хүндруүлэн зүйлчлэхээр заажээ.<sup>94</sup> Үйлдсэн хүчирхийллийн хэлбэрээс шалтгаалан гэм буруутай этгээдэд Эрүүгийн хуулийн 222.12-т заасан дараах шийтгэлийг оногдуулдаг байна. Үүнд:<sup>95</sup>

<sup>94</sup> <https://www.legifrance.gouv.fr/affichCode.do?cidTexte=LEGITEXT000006070719>

<sup>95</sup> <https://www.genderperspectives.by/events/news/kak-reshayut-problemu-domashne-go-nasiliya-vo-frantsii/>

**Хүснэгт 12. Франц Улсын Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт оноғдуулах ял, шийтгэлийн хэлбэрүүд<sup>96</sup>**

Гэмт хэрэг	Эрүүгийн ял, шийтгэл
Бие махбодын гэмтэл учруулсан, тахир дутуу болгосон хүчирхийлсэн үйлдэл	3-5 жилийн хорих ял мөн 45 000-75 000 европийн тorgууль үйлдэл
Хөдөлмөрийн чадвараа алдахад хүргэсэн хүчирхийлсэн үйлдэл	5-10 жилийн хорих ял мөн 100 000 евро хүртэлх тorgууль
Амь насанд нь хохирол учруулахаар заналхийлэх	3 жилийн хорих ял, 45 000 европийн тorgууль
Бэлгийн хүчирхийлэл	7 жилийн хорих ял, 100 000 евро хүртэлх тorgууль
Болгоомжгүй байдлаар амь насанд хохирол учруулсан хүчирхийлсэн үйлдэл	20 жилийн хорих ял
Хүчиндэх	20 жил хүртэлх хугацааны хорих ял

Франц Улс нь Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (CEDAW)-д 2000 онд, Станбулын конвенцод 2014 онд тус тус нэгдэн оржээ. Тус улс нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх бие даасан хуульгүй бөгөөд Эрүүгийн хуулийн зарим гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд гэр бүлийн хүчирхийллийг оруулж эрүүгийн хариуцлага оногдуулах, гэмт хэргийн шинжгүй хүчирхийлэлд захиргааны хариуцлага хүлээлгэх байдлаар зохицуулж ирсэн байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй хэрхэн тэмцэж ирснийг цаг хугацааны үечлэлээр авч үзье.

**1989 он.** Франц Улсад гэр бүлийн хүчирхийлэл гэх асуудалд онцгой анхаарал хандуулалгүй явж ирсэн бөгөөд дөнгөж 1989 онд энэ асуудлаар үндэсний хэмжээний мэдээлэл түгээх аян өрнөсөн байна.

**1990 он.** Давж заалдах шатны шүүх анх удаа гэр бүлийн харилцаанд оршиж буй хүмүүсийн хувьд хүчиндэх гэмт хэрэг гэх

<sup>96</sup> [https://www.legislationonline.org/download/id/3316/file/France\\_Criminal%20Code%20updated%20on%202012-10-2005.pdf](https://www.legislationonline.org/download/id/3316/file/France_Criminal%20Code%20updated%20on%202012-10-2005.pdf)

ойлголт байхыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд 1994 оны Эрүүгийн хуульд тус гэмт хэрэг нь хүндрүүлэх бүрэлдэхүүн болж хуульчлагдсан.

**1992 он.** Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүдэд зориулсан тусгай утастай болсон байна (Violences conjugales – Femmes Info Services).

**2004 он.** Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх анхны төлөвлөгөөг 2005-2007 онд хэрэгжүүлэхээр баталсан ба үүний дараа дахин дөрвөн удаа гурван жилийн үндэсний төлөвлөгөө баталжээ. Сүүлийнх нь 2017-2019 оны төлөвлөгөө юм.

**2006 он.** Эрүүгийн хууль дахь зохицуулалтууд “чангарсан” буюу хамтран амьдрагчдын хүчирхийлсэн үйлдэлд хүлээлгэх хариуцлагын хэмжээ нэмэгдэж, хүчиндэх гэмт хэрэгт 15 жилийн хорих ял оногдуулдаг болсон бол гэр бүлийн гишүүнээ хүчиндсэн тохиолдолд 20 жилийн хорих ял оногдуулж байхаар хуульчилсан байна.

**2007 он.** Франц Улсын 3919 гэх тусгай дугаарын утасны үйлчилгээ нэвтэрсэн бөгөөд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүн сэтгэл зүйн зөвлөгөө авах, дараа дараагийн арга хэмжээний талаар чиглэл авах боломжтой болсон юм.

**2010 он.** Шүүхийн хамгаалалтын захирамж (Ordonnance de protection/PROTECTION ORDER) гэх баримт бичиг 2010 оноос гарч, гэр бүлийн асуудал эрхэлсэн шүүгчийн гаргасан энэхүү захирамжийн дагуу хүчирхийлэгч нь өөрийн хохирогч буюу гэр бүлийн гишүүнтэйгээ уулзах, түүнд ойртохыг дөрвөн сар хүртэлх хугацаагаар хязгаарласан байна. Харин 2014 оноос энэ хугацаа зургаан сар хүртэл болж өөрчлөгдсөн. Үүнтэй ижил зохицуулалтыг Европын Холбооны бусад улс орон, тухайлбал, Испанийн Хаант Улс мөн хэрэгжүүлдэг байна. ХБНГУ-д 2002 оноос хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Хүчирхийллийн эсрэг хамгаалалтын тухай хуулиар (The Act on Protection against Violence<sup>97</sup>, Gewaltschutzgesetz) мөн Франц Улсын дээрх хамгаалалтын арга хэмжээтэй ижил

<sup>97</sup> [https://www.hilfe-info.de/WebS/hilfeinfo/EN/KnowYourRights/GewaltschutzGesetz/GewaltschutzGesetz\\_node.html](https://www.hilfe-info.de/WebS/hilfeinfo/EN/KnowYourRights/GewaltschutzGesetz/GewaltschutzGesetz_node.html)

төстэй зохицуулалтыг хуульчилжээ. Тус хуулийн 1 дүгээр зүйлд гэр бүлийн хүчирхийлэгчийг гэрээс нь гаргах шийдвэр гаргаж болох тухай зохицуулсан. Өөрөөр хэлбэл, ирээдүйд гарч болох давтан хүчирхийллээс сэргийлэх зорилгоор хүчирхийлэгч, хохирогч хоёрыг тусад нь байлгадаг. Энэ тогтолцоог Европын бусад орон, тухайлбал, Бүгд Найрамдах Австри Улс ч мөн хэрэгжүүлдэг бөгөөд хуульдаа тусгасан байна.<sup>98</sup> Тус улсын жишээнд дурдсан Emergency Barring Order-той ижил захирамж юм.

**2019 он.** 2019 онд эрх баригчдын зүгээс гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх асуудлаар тусгай бага хурал зохион байгуулан, уг хурлаас хүчирхийлэлтэй тэмцэхэд анхаарах 60 зөвлөмж боловсруулжээ. Тус улсын Бүгд найрамдах намын зүгээс санал болгосон цахилгаан бугуйвч хэрэглэх тухай хуулийн төслийг Үндэсний хурлаараа дэмжсэн бөгөөд хүчирхийлэгч нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчид ойртохыг хориглосон Ordonnance de protection/PROTECTION ORDER хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавихаар хүчирхийлэл үйлдсэн этгээдэд цахилгаан бугуйвч зүүлгэх зохицуулалттай болсон байна.

**2020 он.** 2020 оны 7 дугаар сард Франц Улсын парламент Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль баталсан байх бөгөөд бүтцийн хувьд тус хууль нь бие даасан шинжтэй бус харин бусад (Иргэний, Иргэний процессын, Эрүүгийн, Эрүүгийн процессын) хуулийн зарим зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан шинж, бүтэцтэй байна.<sup>99</sup>

Дээрх хуулийн нэг онцлог нь эрүүл мэндийн нууцтай холбоотой асуудлыг “илчлэх” боломжийн тухай зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, өвчтөнийг эмчилж буй эмч, эрүүл мэндийн байгууллагын бусад ажилтнууд нь тухайн өвчтөний эрүүл мэндэд гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй аюул, заналхийлэл байна хэмээн үзээд тэдгээр өвчтөнүүд өөрийгөө хамгаалах чадваргүй/боломжгүй хэмээн үзвэл холбогдох байгууллагад хүчирхийллийн тухай мэдээллийг

<sup>98</sup> [http://www.ikf.ac.at/english/austrian\\_legislation\\_against\\_domestic\\_violence.pdf?fbclid=IwAR0AxYDFD4lu-xK9F-Ef1sb6ZU-adU-3DqRjegdoDbhzm2XyA0C-hG9lFMM](http://www.ikf.ac.at/english/austrian_legislation_against_domestic_violence.pdf?fbclid=IwAR0AxYDFD4lu-xK9F-Ef1sb6ZU-adU-3DqRjegdoDbhzm2XyA0C-hG9lFMM)

<sup>99</sup> <https://perma.cc/4HPF-SKD7>

шууд өгөх эрх хэмжээтэй болсон байна.<sup>100</sup> Энэ нь нэг талаас эрүүл мэндийн нууцыг задруулж буй хэрэг боловч нөгөөтээгүүр гэр бүлийн хүчирхийлэгчийн эрхшээлд буй хохирогчид туслах арга хэмээн үзжээ.

Мөн гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч нь улсаас олгох орон байранд ээлж дараалалгүй орох эрхтэй байх бөгөөд хүүждийн болон ажилгүйдлийн халамж авах боломжтой байдаг ажээ. Франц Улсын Эрүүгийн хэргийн шүүх хохирогчийн аюулгүй байдлыг хангахын тулд дараах арга хэмжээг нэн даруй авах эрх хэмжээтэй. Үүнд:

- Хохирогчийн амьдарч буй хаяг, байршилыг нуух, халамжийн байгууллагад орогох боломж олгох;
- Хүчирхийлэл үйлдэгчийг гэр, орон байрнаас нь хүчээр гаргах;
- Хохирогчид ойртох, уулзах эрхийг хязгаарлах;
- Хохирогчийг эмнэлгийн хяналтад орохыг үүрэг болгох;
- Түр саатуулах зэрэг болно.<sup>101</sup>

Франц Улсын жишээнээс харахад тус улс нь Австрийн нэгэн адил гэр бүлийн хүчирхийллийг бие даасан гэмт хэрэг бус, зарим гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчилсан байна. Францад 2020 онд гэр бүлийн хүчирхийллээс үүдэн нас барсан хүн 106 байсан бөгөөд үүний 90 нь эмэгтэйчүүд байжээ. Харин 2019 онд нас барсан хүн 173, үүний 146 нь эмэгтэй байсантай харьцуулахад 2020 оны үзүүлэлт буурчээ. Франц Улсын Хууль зүйн сайд Йирик Du-pond-Moretti энэ төрлийн гэмт хэргийн тоо буурсан нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэж буй Засгийн газар, нийгэм, түүнчлэн төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны эерэг үр дүн хэмээгээд 2019 онд Франц Улсын Засгийн газраас зохион байгуулсан

<sup>100</sup> [https://www.loc.gov/item/global-legal-monitor/2020-08-07/france-parliament-adopts-law-against-domestic-violence/?fbclid=IwAR2BQrvvwhrOj0TbGVwXW1fgC-ceCa8afHZrYSMk0C7hChwmXmD3ftt\\_ajMY](https://www.loc.gov/item/global-legal-monitor/2020-08-07/france-parliament-adopts-law-against-domestic-violence/?fbclid=IwAR2BQrvvwhrOj0TbGVwXW1fgC-ceCa8afHZrYSMk0C7hChwmXmD3ftt_ajMY)

<sup>101</sup> <https://www.genderperspectives.by/events/news/kak-reshayut-problemu-domashnego-nasiliya-vo-frantsii/>

дугуй ширээний уулзалт, хурлаас гарсан шийдвэр, зөвлөмжийн үр дүн гэж үзсэн байна.<sup>102</sup> Тодруулбал, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийг газар зүйн байршил тогтоох технологийн дагуу хаана байгааг нь илрүүлж, хохирогчид ойртож буй тохиолдолд яаралтай арга хэмжээ авах болсон, хохирогч хүчирхийлэлд өртөх үедээ ганцхан товчин дээр дарж дуудлага өгөх боломж бүрдүүлэн, тусгай утас нэвтрүүлсэн, хүчирхийлэгчийг хохирогчийн гэрээс тусгаарлах албадлагын арга хэмжээ авах боломжтой болсон зэрэг юм. Франц Улс нь эдгээр дэвшилтэт арга хэмжээг авахын зэрэгцээ Станбулын конвенцод заасан зохицуулалтыг тусгаж, GREVIO-гоос өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг бууруулахад эерэг нөлөө үзүүлж байна хэмээн дүгнэж болохоор байна.

### 3.3. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

Оросын Холбооны Улс (цаашид “ОХУ” гэх)-ын хууль тогтоомжоор гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд захиргааны болон эрүүгийн хариуцлага оногдуулах эрх зүйн зохицуулалттай. Тус улсад хохирогчийн эрхийг дараах хоёр үе шатаар хамгаалдаг байна. Үүнд:

1. Цагдаа буюу хууль сахиулагч байгууллагад дуудлага өгөх, түүний дараа хүчирхийлэл үйлдэгчийг эрүүгийн эсхүл захиргааны хариуцлагад татах;
2. Биет болон биет бус хохирлыг иргэний эрх зүйн журмаар нөхөн төлүүлэх.<sup>103</sup>

<sup>102</sup> <https://www.france24.com/en/europe/20210203-france-announces-sharp-drop-in-femicides-but-ngos-say-it-s-too-early-to-rejoice>

<sup>103</sup> Эрүүгийн болон захиргааны журмаар хэргийг хянан шийдвэрлэх явцад цугларсан нотлох баримт нь иргэний журмаар хохирол нөхөн төлүүлэх ажиллагааны явцад ашиглагдах, ажиллагааг хялбарчлах, түргэвчлүүлэх давуу тал бий болгодог тул дээр дурдсан үе шатны дагуу ажиллагаа явуулах нь практик ач холбогдолтой байдаг байна.

Харин хохирогчийн биед хүнд гэмтэл учруулаагүй тохиолдолд ОХУ-ын Эрүүгийн хуулийн дараах заалтуудаар хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага тооцдог байна. Үүнд: Эрүүгийн хуулийн 115 дугаар зүйл (Эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулах)-ийн 115.1-д “Хүний эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулсны улмаас түр хугацаагаар эрүүл мэндийг нь сарниулсан эсхүл ерөнхий хөдөлмөрийн чадварыг үл ялиг алдагдуулсан бол торгох эсхүл албадан ажил хийлгэх эсхүл засан хүмүүжүүлэх зорилгоор хөдөлмөрлүүлэх эсхүл дөрвөн сар хүртэлх хугацаагаар баривчлах” зэрэг ял шийтгэхээр хуульчилжээ. Мөн хуулийн 116 дугаар зүйл (Зодох)-ийн 116.1-д “Энэ хуулийн 115 дугаар зүйлд заасан үр дагаврыг үүсгээгүй бөгөөд танхайрах эсхүл улс төр, арьс өнгө, яс үндэс, шашин шүтлэгээр үзэн ядах эсхүл нийгмийн тодорхой бүлгийг үзэн ядах, дайсагнах сэдлээр зодох эсхүл бусад хүч хэрэглэсэн үйлдлийн улмаас бие махбодод гэмтэл учруулсан бол албадан ажил хийлгэх эсхүл засан хүмүүжүүлэх зорилгоор хөдөлмөрлүүлэх эсхүл хорих эсхүл баривчлах” зэрэг ял шийтгэхээр хуульчилжээ.

2017 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар<sup>104</sup> ОХУ-ын Төрийн Дум Эрүүгийн хуулийн дээрх 116 дугаар зүйлд байсан “ойр дотнынхоо хүнийг” гэсэн томьёоллыг хассанаар ямар нэг гэмтэл учруулалгүй бие махбодын хүчирхийлэл үйлдсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх зохицуулалт хийсэн нь тухайн үедээ ихээхэн шүүмжлэл дагуулсан байна.

Дээрх хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр гэр бүлийн хамаарал бүхий хүнээ зодсон хүчирхийлэл үйлдэгчийн эхний удаагийн үйлдэлд захиргааны хариуцлага хүлээлгэх бөгөөд энэ нь торгох, баривчлах, албадан хөдөлмөрлүүлэх зэрэг шийтгэл байна. Захиргааны хариуцлагыг 2001 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Захиргааны зөрчлийн тухай хуулиар зохицуулдаг бөгөөд гэр

<sup>104</sup> <https://www.interfax.ru/russia/548888>

бүлийн хүчирхийлэл үйлдэгчид тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасан “Зодох” гэсэн заалтаар хариуцлага тооцдог.<sup>105</sup>

Харин давтан хүчирхийлэл үйлдсэн эсхүл бие махбодод гэмтэл учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй юм.<sup>106</sup> Энэхүү “давтан хүчирхийлсэн” гэх ойлголтод нэгээс дээш буюу хоёр, гурав дахь удаагийн үйлдлийг ойлгохоор зохицуулсан байх бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “байнга” гэх шинжтэй ижил байх хэдий ч ОХУ-ын хувьд нэгээс дээш буюу хоёр дахь удаагийн үйлдлээс шууд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааснаараа манай улсын практикаас ялгамжтай байна.

Олон улсын байгууллага, тухайлбал, Европын хүний эрхийн шүүхээс “ОХУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжууд нь гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд хангалтгүй байгаа бөгөөд 2016-2017 оны хоорондох богинохон хугацааг эс тооцвол ОХУ нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилж байгаагүй, гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн байдлаар ч зохицуулж байгаагүй” тухай онцолсон байна. Түүнчлэн 2017 онд эрүүгийн хуульд оруулсан өөрчлөлтийн дараа хүчирхийлэл үйлдэгч хариуцлага хүлээхгүй байх явдал нэмэгдэж гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал дордсоныг Хүний эрхийн байгууллага (Human Rights Watch) мэдэгджээ. Тэдний үзэж буйгаар ОХУ дахь таван эмэгтэй тутмын нэг нь ойр дотнын хүний зүгээс хүчирхийлэлд өртөж байсан хэдий ч тэдгээрийн 60-70 хувь нь энэ тухайгаа мэдэгдэлгүй өнгөрдөг гэжээ.<sup>107</sup>

ОХУ-ын хууль зүйн зохицуулалтад хохирогч нь өөрөө гомдол гаргасан тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэдэг тогтолцоо нь гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, илрүүлэх зорилгыг биелүүлэхэд хүндрэл учруулж байгааг харж болохоор байна. Учир нь бодит байдалд хүчирхийлэлд өртсөн хүн цагдаад мэдэгдэх, шүүх, прокурорын байгууллагад хандан хэргээ шийдвэрлүүлэхээс

<sup>105</sup> [http://www.consultant.ru/document/cons\\_doc\\_LAW\\_34661/60181baf1ef1b44ac-9f14a132d960f0008f1c155/](http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34661/60181baf1ef1b44ac-9f14a132d960f0008f1c155/)

<sup>106</sup> <https://cyberleninka.ru/article/n/nasilie-v-semie-problema-sotsialnaya-i-pravovaya/viewer>

<sup>107</sup> <https://www.kommersant.ru/doc/3944832>

эмээдэг. Энэ нь хүчирхийлэгч буюу нөхөр, хамтран амьдрагчдынхаа хүчирхийлэлд дахин өртөх, түүнчлэн эдийн засгийн хувьд хараат байдаг тул өөрийгөө болон хүүхдээ тэжээн тэтгэх чадваргүй болно гэх айдсаас үүдэлтэй.

Дээрх нөхцөл байдлын улмаас хууль хэрэгжихгүй байгаа болон хүчирхийллийн тоо жил бүр нэмэгдсэнтэй холбогдуулан ОХУ-ын Төрийн Думын зарим гишүүн “Гэр бүл-ахуйн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн төсөл<sup>108</sup> боловсруулан 2016 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр албан ёсоор Төрийн Думд өргөн барьсан байна. Энэхүү хуулийн төслийг анх 2019 оны 12 дугаар сард олон нийтэд ил байршуулан санал авсан бөгөөд томьёолол, хууль зүйн техникийн хувьд ойлгомжгүй, тодорхой бус, гэм буруутай нь шүүхээр тогтоогдох хүртэл хэн ч гэм буруутайд тооцогдохгүй байх эрх зүйн үндсэн зарчим зөрчигдсөн, ашгийн төлөө бус байгууллагууд гэр бүлийн дотоод асуудалд хэт ихээр оролцох боломж бүрдсэн зэрэг олон тооны шүүмжлэл иргэд болон хуульчдын зүгээс иржээ.

Тус хуулийн төслийн 2 дугаар зүйлд гэр бүл-ахуйн хүчирхийлэл гэдгийг “захиргааны зөрчлийн эсхүл эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинж агуулаагүй бие махбодын, сэтгэл зүйн, эд хөрөнгийн хохирол учруулахаар заналхийлж буй эсхүл учруулсан санаатай үйлдэл” хэмээн тодорхойлсон байна. Мөн энэ зүйлд “гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хууль эрх зүй, эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх цогц аргаас бүрдэх бөгөөд хүчирхийлэлд өртсөн этгээдийн эрхийг хамгаалах, тусlamж үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж байгаа шалтгааныг олж илрүүлэх, арилгах, хүчирхийлэл үйлдэгчийг шийтгэхэд чиглэнэ” хэмээн заажээ.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрх бүхий этгээдэд ОХУ-ын прокурорын байгууллага, Ерөнхийлөгчийн дэргэдэх Хүүхдийн эрхийн асуудал хариуцсан эрх бүхий этгээд, хүний эрхийн асуудал хариуцсан эрх бүхий этгээд, эрүүл мэндийн

<sup>108</sup> <http://council.gov.ru/media/files/rDb1bpYASUAxolgmPXEfKLUIq7JAARUS.pdf>

байгууллага, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлд үйл ажиллагаа эрхэлдэг ашгийн төлөө бус байгууллагууд зэрэг 12 нэр төрлийн субъект хамаарч байна. Эдгээр субъект нь “урьдчилан сэргийлэх байдлаар хяналт тавих, бүртгэл хөтлөх, хүчирхийлэл үйлдсэн тухай өргөдөл гомдол хүлээн авч түүнийг таслан зогсоох арга хэмжээ авах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн этгээдийг нийгмийн халамж болон эрүүл мэндийн байгууллагад хүргэх, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авах тухай хүсэлтийг шүүхэд гаргах” зэрэг арга хэмжээ авах эрх хэмжээтэй. Мөн хуулиар зөвхөн хүчирхийлэлд өртсөн этгээд бус тухайн хүчирхийллийг харсан эсхүл мэдсэн дурын этгээд гомдол гаргах, дуудлага өгөх эрхтэй байхаар зохицуулжээ.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл нь “гэр бүлийн хүчирхийлэл” гэдгийг тодорхойлохдоо хэт ерөнхий буюу зөрчил эсхүл эрүүгийн гэмт хэрэгт хамаарахаас бусад бүх үйлдлийг ойлгож болохоор томьёолсон, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх эрх бүхий этгээдэд бараг бүхий л төрийн байгууллага, тэдгээрийн ажилтан, нийгмийн ажилтан, багш, эмч, хөрш, төрийн бус байгууллага зэрэг маш өргөн хүрээний хүмүүсийг хамруулсан байгаа нь гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс хэт оролцсон, хувийн болоод гэр бүлийн амьдрал, нууц зэрэгт халдсан, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байгаа гэх томьёолол дор гэм буруутай эсэх нь тогтоогдоогүй байгаа этгээдэд арга хэмжээ авах (хяналт тавих, бүртгэл хийх зэрэг), гэр бүлийн гишүүнтэйгээ уулзах, холбоо барих, харилцахыг хориглож байгаа нь хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн зохицуулалтууд болсон тухай судлаачид дүгнэсэн байна.<sup>109</sup>

ОХУ-ын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний нийгмийн хөгжлийн болон хүний эрхийн зөвлөл нь гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг эцэслэн засварлах ажлын хэсэг байгуулсан бөгөөд тус хуулийг 2021 оны сүүлээр батлуулахаар ажиллаж байсан хэдий ч өнөөдрийг хүртэл батлагдаагүй байна.

<sup>109</sup> <http://www.familypolicy.ru/rep/rf-19-051-01.pdf>

ОХУ-ын хууль зүйн зохицуулалтаас дүгнэхэд нэгдүгээрт, Эрүүгийн хууль дахь зарим гэмт хэргийн хувьд гэр бүлийн хүний эсрэг үйлдсэн бол хүндрүүлэх нехцөл байдал байхаар заасан байна. Гэвч зарим гэмт хэргийн хувьд энэхүү зохицуулалтыг өөрчлөн захиргааны зөрчил болгосон нь нийгмийн бухимдал, эсэргүүцэлтэй тулгараад зогсохгүй практикт сөрөг үр дагавар бий болгосныг харж болохоор байна. Хоёрдугаарт, улс орнуудын гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийн стандарт, нормыг тогтоосон Станбулын конвенцод нэгдэх эсхүл түүний зохицуулалтаас авч хэрэгжүүлэхийн оронд өөрийн улсын Үндсэн хууль, хүний эрхийн ойлголт, хэм хэмжээг зөрчсөн хуулийн төсөл боловсруулан батлуулахаар төлөвлөж байгаа нь батлагдаагүй байхдаа ч хуульч, гэр бүлийн эрхийг хамгаалагч төрийн бус байгууллага, эрдэмтэн, судлаачдын шүүмжлэлийг дагуулж байгаагаас харахад сайн зохицуулалт болж чадаагүй хэмээн дүгнэхээр байна.

### 3.4. ЯПОН УЛС

*Эрүүгийн хууль тогтоомж болон гэр бүлийн хүчирхийлэл<sup>110</sup>*

Япон Улсад хэрэв хохирогчийн бие махбодод халдаж, хохирогч энэ тухай Эрүүгийн хуулийн дагуу гомдол гаргасан тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хохирогчийн бие махбодод гэмтэл учирсан тохиолдолд Эрүүгийн хуулийн 204-р зүйлийн дагуу буруутай этгээд нь засан хүмүүжүүлэх ажил хийж, 15 жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгүүлэх эсхүл 500,000 иен хүртэл хэмжээний торгууль төлөх үүрэг хүлээдэг. Хэрэв халдлагын үр дүнд хохирогчийн бие махбодод ямар нэг гэмтэл учраагүй бол засан хүмүүжүүлэх ажил хийж, хоёр жил хүртэлх хугацаагаар хорих ял шийтгүүлэх эсхүл 300,000 иен хүртэлх хэмжээний торгууль төлөх; засан хүмүүжүүлэх ажил хийхгүйгээр

<sup>110</sup> Violations of Women's Rights in Japan: Alternative report to the united nations committee against torture 38th session, 2007.

[https://tbinternet.ohchr.org/Treaties/CAT/Shared%20Documents/JPN/INT\\_CAT NGO\\_JPN\\_38\\_9270\\_E.pdf](https://tbinternet.ohchr.org/Treaties/CAT/Shared%20Documents/JPN/INT_CAT NGO_JPN_38_9270_E.pdf)

хорих ялаар шийтгүүлэх эсхүл бага хэмжээний торгууль төлөх ялаар тус тус шийтгүүлэхээр зохицуулсан байна.

